

ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГААС ЦАГААНДЭЛГЭР СУМЫН ЗАСАГ ДАРГАТАЙ
БАЙГУУЛСАН 2018 ОНЫ ҮР ДҮНГИЙН ГЭРЭЭНИЙ ХЭРЭГЖИЛТ

2018.12.14

ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН ХҮРЭЭНД
ХЭРЭГЖҮҮЛЭХ ХӨТӨЛБӨР, АРГА ХЭМЖЭЭ

№	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Хэрэгжилт	Хувь
Хөтөлбөр 1.Төрийн албаны стандартыг мөрдүүлж, албан хаагчдыг сургаж, чадваржуулах, тэдний ёс зүй, ажлын хариуцлагыг өндөржүүлэн, боловсон хүчний хангамжийг нэмэгдүүлнэ.			
1.1	Байгууллага бүр үйл ажиллагааны болон хүний нөөцийн ил тод байдлыг хангах чиглэлээр “Мэдээллийн ил тод байдал, мэдээлэл авах эрхийн тухай хууль”-д заасан үйл ажиллагааг хэрэгжүүлж ажиллана.	-Байгууллагын эрхэм зорилгыг үүдний хэсэгт үйлчлүүлэхээр орж ирж байгаа иргэдэд харагдахуйц томоор бичиж байрлуулсан ба нийт ажилтан албан хаагчдын ажлын чиг үүрэг холбогдох утасны дугаарыг хаалганы гадна хэсэгт тус тус байруулсан. -Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн дагуу байгууллагын үйл ажиллагааны болон хүний нөөцийг ил тод байдлын самбар байрлуулж тухай бүр мэдээллийн шинэчилж ажиллаж байна. Үйл ажиллагааны болон хүний нөөцийн холбогдох мэдээллийг цахим хуудас болон мэдээллийн самбартаа ойлгомжтой байдлаар байрлуулсан.	100
1.2	Төрийн албаны тухай хуулийн 33.6.-д заасан дагуу төрийн байгууллагуудад албан хаагчдын сургалтын болон ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийг хэрэгжүүлэх жилийн төлөвлөгөө гарган хэрэгжүүлж, үр дүнг хагас бүтэн жилээр тооцон эрчимжүүлж ажиллах	ЗДТГ-ын дотоод хяналтын нэгжээс ажилтан албан хаагчдаас ажиллах орчны сэтгэл ханамж болон тэдэнд тулгамдаж буй асуудлаар санал асуулга авч нэгтгэн дүгнэсэн. Судалгааны дүнгээс харахад ололттой сайн талууд байгаа ч цаашид анхаарах үйл ажиллагаандаа тусгаж хэрэгжүүлэх дутагдалтай талууд бас байлаа. Мөн төрийн албан хаагчийн ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах, сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэх 2018 оны төлөвлөгөөг оны эхэнд батлан хэрэгжүүлэн ажиллалаа. ТАХ-ын сургалтын хөтөлбөр 12 заалттай ба хэрэгжилт 90, ТАХ-ын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөр 19 заалттай ба хэрэгжилт 90%-тай хэрэгжсэн байна.	100
1.3	Төрийн албаны стандарт, заавар журмуудыг байгууллагуудынхаа үйл ажиллагаанд мөрдүүлж, хэрэгжилтийн байдалд хяналт үнэлгээ хийж, 1-2 байгууллагын удирдлагуудын сонсгол мэдээллийг хэлэлцэж, дүгнэлт зөвлөмж гаргаж ажил сайжруулах арга хэмжээ авч ажиллах.	ЗДТГ-ын тушаалаар ажлын хэсэг байгуулан бүх ажилтан албан хаагчдын ажлын байрны тодорхойлолтыг шинэчлэн боловсруулж, үр дүнгийн гэрээ хөдөлмөрийн гэрээ байгуулсан. Бүх ажилчдын хувийн хэргийг ТАЗ-ийн 2004 оны 18-р тогтоолоор батлагдсан журмын дагуу бүрдүүлсэн. Тус суманд шаардлагатай байгаа соёлын төвийн хөгжмийн багш, ЗДТГ-т газрын даамал, нийгмийн халамжийн мэргэжилтэн, нийгмийн даатгалын байцаагч, улсын бүртгэгч, төрийн сангийн мэргэжилтэн, байгаль орчны байцаагчийн сул орон тоо гарснаас 3 сул орон тоог нөхөж 3 ажлын байранд төрийн албаны шалгалт зарлагдаад байна. Мөн ЭМТ-ын даргын ажлын байрыг ТАСЗ-д захиалга хүргүүлсэн. Хөгжмийн багшийн ажлын байрны зарыг цахим сүлжээ болон мэдээллийн самбарт зарыг тавьж байна. Мэдээллийн цагаар соёлын төв, ЭМТ, ЕБС, цэцэрлэгийн үйл ажиллагааны талаарх мэдээллийг сонсож ажилласан.	100
1.4	Сумынхаа хүний нөөцийг хөгжүүлэх, тогтвор суурьшилтай ажиллуулах хөтөлбөр, төлөвлөгөө гарган	Төрийн албан хаагчдын мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх чиглэлээр улс аймаг, орон нутгаас зохион байгуулсан сургалт семинарын үйл ажиллагаанд тухай бүр тогтмол хамруулж ажилласан. 2018 онд улс аймаг,	100

	хэрэгжүүлж, орон нутгаа мэргэжлийн боловсон хүчнээр хангах арга хэмжээ авах	бүсийн сургалтанд 17 албан хаагч хаагч тус бүр 1-5 удаа аймгийн төвд 17, хотод 5 удаагийн сургалтад хамрагдсан байна. Сургалтад хамрагдаад ирсэн албан хаагчид долоо хоног бүрийн Лхагва гарагийн мэдээллийн цагаар иргэд, төрийн албан хаагчдад сургалт семинарын талаарх мэдээллийг тавьж хэвшсэн. 2018 онд дутагдалтай боловсон хүчний судалгааг хагас бүтэн жилээр гаргаж аймгийн ЗДТГ-т хүргүүлсэн. Суманд судалгаагаар 108 мэргэжилтэй боловсон хүчин, 42 оюутан байна. мөн сумын хэмжээнд дутагдалтай байгаа боловсон хүчний судалгааг улирал тутам гаргаж ажилласан. ЗДТГ-т 2018 онд 4, ЕБС-д 6, цэцэрлэг, соёлын төвд тус бүр 1, ЭМТ-д 4 боловсон хүчин дутагдалтай байснаас ЗДТГ-т 1, ЕБС-д 4, цэцэрлэгт 1, ЭМТ-д 3 орон тоог нөхөж ажилласан байна. Төрийн албаны салбар зөвлөлд 4 ажлын байрны захиалгыг хүргүүлж 3 ажлын байрны зарыг мэдээллийн самбар болон цахим сүлжээгээр нийтэд зарласан байна. Төрийн албаны хэвийн ажиллагааг хангахын тулд төрийн сангийн мэргэжилтэн, байгаль орчны байцаагчийн ажлыг түр хавсруулан ажиллуулж байна. мэргэжлийн боловсон хүчнийг тогтвор суурьшилтай ажиллуулах нөхцлийг бүрдүүлэх ажлын хүрээнд багш нарын орон сууцыг нийтийн халаалтанд холболоо. Цаашид ЗДТГ-ын ажилчдын орон сууц, ЭМТ-ийн хуучин эмнэлгийг ажилчид байрлуулах зорилгоор засварлах, нийтийн халаалтанд холбуулах ажлыг төлөвлөөд байна. Мөн соёлын төвийн номын санч, ЗДТГ-ын ЖДҮ хариуцсан мэргэжилтэн, цэцэрлэгийн туслах багшийг дээд сургуульд суралцахад нь цалинтай чөлөө олгох зэргээр дэмжиж ажилласан байна.	
1.5	Төрийн байгууллагуудын төлөвлөгөөнд төрийн албан хаагчдын ёс зүй, сахилга хариуцлагыг дээшлүүлэхэд чиглэгдсэн ажил арга хэмжээг тусган хэрэгжүүлж, үр дүнг тооцож ажиллах	Төрийн албан хаагчийн ёс зүй, сахилга хариуцлагыг дээшлүүлэх талаар гарсан 3Г-ын 2017 оны 01 албан даалгавар, 2018 оны 32-р тогтоол, 258-р тогтоолуудыг хэрэгжүүлэх төлөвлөгөөг байгууллага бүр гарган баталж хэрэгжүүлж ажилласан. Байгууллагын дэргэд ёс зүйн хороог шинэчлэн байгуулж ажиллах журам, ажлын төлөвлөгөөг баталсан. Бүх мэргэжилтэн, ажилтнуудтай ёс зүй хариуцлагын гэрээг байгуулсан. Ёс зүйн зөрчил гаргасан 2 албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулсан. Төрийн албан хаагчийн ёс зүйтэй холбоотой 1 гомдол ирснийг ёс зүйн хороонд шилжүүлж шийдвэрлэсэн. Төрийн албан хаагчдын сахилга хариуцлагыг дээшлүүлэх чиглэгдсэн төрийн албан хаагчдын зөвлөгөөнийг 2018.10.29-ний өдөр зохион байгуулж төрийн албан хаагчид идэвхтэй зохион байгуулалт сайтай хамрагдсан. Сахилга хариуцлага дээшлүүлэх тогтоол шийдвэрүүдийг хэрэгжүүлж ажилласнаар төрийн албан хаагчдын ажлын хариуцлага нэмэгдэж ажлын бүтээмж сайжирч байна.	100
1.6	Төрийн захиргааны болон үйлчилгээний удирдах ажилтны томилгооны зөрчил гаргахгүй ажиллах	Төрийн үйлчилгээний удирдах ажилтнуудаас томилгооны зөрчилтэй удирдах ажилтан байхгүй. Төрийн захиргааны албан хаагчаас 2 мэргэжилтэн түр томилогдон ажиллаж байна. ТА3-д ажлын байрыг зарлах захиалга өгсөн.	100
Хөтөлбөр-2. Орон нутаг дахь төрийн байгууллагуудын үйл ажиллагааг иргэдэд сурталчлах нөхцөлийг ханган, төрийн ажил үйлчилгээг хүргэх арга замыг боловсронгуй болгох			
2.1	Төрийн байгууллагын нэгдсэн портал сайт www.dundgovi.gov.mn болон өөрийн цахим хуудас, бусад мэдээллийн хэрэгслээр дамжуулан сумынхаа үйл	ЗДТГ-ын бичиг хэргийн ажилтан сум орон нутагт зохион байгуулагдсан үйл ажиллагааны талаарх мэдээллийг аймгийн цахим хуудсанд, нийгмийн даатгалын байцаагч Цагаандэлгэрийн мэдээ группт тус тус мэдээллийг тогтмол оруулж ажиллаж байна. Байгууллага бүр мэдээллийн ил тод байдлын самбартай болсон ба	100

	ажиллагааг иргэдэд нээлттэй ил тод мэдээлэх цаг үеийн мэдээллийг тухай бүр байршуулж, мэдээллийн баяжилтыг сайжруулах	мэдээ мэдээллийн тухай бүр байршуулж шинэчлэн баяжуулж байна.	
2.2	Тухайн орон нутагт зохион байгуулсан үйл ажиллагаа, удирдлагын зүгээс гаргасан тогтоол шийдвэр, хурал зөвлөмжийн мэдээллийг тухай бүр ирүүлж, аймгийн телевиз, хэвлэл, мэдээллийн, хэрэгслээр сум орон нутагаа сурталчилах	Сум орон нутагт зохион байгуулсан үйл ажиллагааг Цагаандэлгэрийн мэдээ фейсбүүк групп, сумын мэдээ, аймгийн цахим хуудсанд байршуулж ажилласан. Удирдлагын зүгээс гарч буй захирамж, тушаалыг мэдээллийн самбарт тухай бүрт байршуулсан. 7 хоног бүрийн Баасан гарагт аймгийн ЗДТГ-ын ХМА-нд тухайн долоо хоногт болсон шинэлэг ажлын мэдээллийг явуулж ажилласан. 2018 онд 52 удаагийн мэдээ явуулахаас 43 удаагийн мэдээг хугацаанд явуулж 9 удаа тасалдуулж 82,6% тай байна.	70
2.3	Иргэдтэй харилцах утас ажиллуулж, иргэдийн санал хүсэлтийг шуурхай шийдвэрлэдэг болох, сурталчилах	Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтнуудад хандаж ирүүлсэн санал, өргөдөл, гомдлын бүртгэн авч холбогдох ажилтанд өгч шийдвэрлүүлэн хуулийн хугацаанд хариуг өгч ажиллаж хэвшсэн. Төрийн байгууллага, багийн Засаг дарга нар, албан хаагчдад ирүүлсэн СӨГХ-ийг улирал тутам ЗДТГ-ын бичиг хэргийн ажилтан нэгтгэн аймгийн ЗДТГ-т мэдээлдэг. Засаг даргын Тамгын газрын СӨГомдол хүлээн авах утас 89643553, ЭМТ-д 89826055 нээлттэй утаснуудыг ажиллуулж байна. Албан байгууллага, албан хаагч нарт 2018 онд иргэдээс ирүүлсэн санал, өргөдөл, гомдол, ирсэнийг хүлээн авч, холбогдох албан тушаалтанд хяналтын картаар хяналт тавьж, улирал бүрийн эцэст СӨГ-ийн мэдээг нэгтгэн тайланг холбогдох байгууллагад цахимаар болон цаасаар хугацаанд нь хүргүүлж ажилласан. 2018 оны 11 сарын эцсийн байдлаар нийт 335 санал хүсэлт, өргөдөл гомдлоос 331 СӨГ-ийг хуулийн хугацаанд нь шийдвэрлэн, иргэдэд хариуг цаасаар болон утсаар, биеэр уулзаж хариуг өгч ажиллалаа.	100
2.4	Сумын иргэний танхимын үйл ажиллагаанд төрийн болон төрийн бус байгууллага иргэдийн оролцоог ханган жилийн төлөвлөгөө гарган хэрэгжүүлж, үр дүнг тооцож ажиллах	ИТХ-ын дэргэдэх Иргэний танхим нь ИТХ-ын Тэргүүлэгчдээр жилийн төлөвлөгөө гарган батлуулсан. Иргэний танхимаар "Боржигон дэлгэрэх" ТББ, Инвест ко-оп Монгол төсөл болон төрийн байгууллагууд мэдээлэл, сургалт сурталчилгаа, хэлэлцүүлэг явуулж хамтран ажилласан. Энэ онд иргэний танхимаар 5 удаагийн хэлэлцүүлэг, долоо хоног бүрийн Лхагва гараг бүр ЗДТГ-аас мэдээллийн цагийг явуулж хэвшсэн. Мэдээллийн цагаар сумын эрх зүйн хөтөч багаас 2018 онд судлан сурталчлах хууль эрх зүйн актын төлөвлөгөөнд 21 хууль тогтоомжийг судлуулахаар төлөвлөсөн. Үүнээс 11 сарын эцсийн байдлаар 14 хууль тогтоомжийг төрийн албан хаагчдад танилцуулж давхардсан тоогоор 208, төлөвлөгөөнөөс гадна 9 удаагийн мэдээлэл сургалтанд давхардсан тоогоор 216 иргэд, төрийн албан хаагч хамрагдсан.	70
2.6	Иргэдээс төрийн захиргааны байгууллага, албан тушаалтанд хандаж ирүүлсэн өргөдөл, санал, гомдол, хүсэлтийг хууль тогтоомжийн хүрээнд судлан бүрэн эрхийн хүрээнд шийдвэрлэх, хуулийн хугацаанд иргэдэд хариу өгч, тайлагнаж хэвших	Сумын хэмжээнд 2018 оны байдлаар 335 өргөдөл ирснээс 331 өргөдлийг хуулийн хугацаанд нь шуурхай шийдвэрлэсэн бөгөөд судлагдах шатандаа байгаа 4 өргөдөл байна. Байгууллага бүрээр авч үзвэл ЗДТГ-т нийт 257 СӨГ ирсэн байна. Үүнээс хөдөлмөр эрхлэлт, нийгмийн халамж үйлчилгээтэй холбоотой 85, газар эзэмших, ашиглахтай холбоотой 36, ХАА-тай холбоотой 42, шилжих 11, ажлаас чөлөөлөгдөх 8, ажилд орох өргөдөл 4, бэлчээр нутгийн маргаантай 29, мал эмнэлгийн үйлчилгээний холбоотой 25, чөлөө хүссэн 17 өргөдөл байна. ЕБС-д ирсэн ӨГСХ-ийг захирлын дэргэдэх зөвлөлөөр хэлэлцэн шийдвэрлэдэг. Энэ хичээлийн жилд ажлаас чөлөөлөгдөх өргөдөл 5,	100

		ажилд орох өргөдөл 7, ёс зүйн доголдол гаргасан багшийн талаарх өргөдөл 1 ирснийг цаг тухай бүрт нь хуралдан шийдвэрлэж зохих арга хэмжээнүүдийг авдаг. Цэцэрлэгт 15 санал, хүсэлт, ажилд орохыг хүссэн өргөдөл 16, ажлаас гаргах өргөдөл 2, 2 гомдол ирсэн. Ирсэн өргөдөл, гомдол, санал, хүсэлтийн 45% нь ажилд орохыг хүссэн, 5% ажлаас халагдах хүсэлт, 28% барилгын асуудлыг яаралтай шийдвэрлүүлэх санал, 17% бусад асуудлаар оруулсан санал, 5% багшийн зан харилцаатай холбоотой гомдол байлаа. СӨГХ-ийг хугацаандаа шийдвэрлэж шийдвэрлэлийн хувь 88%-тай байна. Хугацаа хүлээгдэж байгаа 1 өргөдөл, ирсэн саналуудаас хэрэгжээгүй 4 санал байна. Байгууллагын ажил сайжруулах санал хүсэлтэнд зориулалтын бус барилгад үйл ажиллагааг явуулж буй тул бүлгийн өрөөг бүрэн камержуулах хүсэлт ирснийг 100% хэрэгжүүлж, эцэг эхчүүдэд танилцуулсан. 2018 онд ЭМТ-д иргэдээс ирсэн санал 1, гомдол 2, ажилд орохыг хүссэн өргөдөл 11, ажлаас халагдах өргөдөл 2, Суралцах хүсэлтэй өргөдөл 6 ирсэн байна. Дотоод хяналт, чанарын багууд хамтран санал, хүсэлт, өргөдөл гомдол шийдвэрлэлтийн байдалд дотоод хяналт хийж ажилладаг. Чанарын багаас 2018 оны туршид 5 удаагийн хяналт шалгалт, халдвар хяналтын багаас 2 удаагийн хяналт шалгалт хийсэг байна. Соёлын төвд 2018 оны жилийн эцсийн байдлаар нийт 4 иргэн өргөдөл гаргасан байна. Үүнд өөрийн хүсэлтээр үүрэгт ажлаас чөлөөлөгдөх 1, ажилд орохыг хүссэн 3 иргэн өргөдөл гаргасныг хуулийн хугацаанд шийдвэрлэж санал хүсэлт, өргөдөл гомдлын дэвтэрт тухай бүр нь бүртгэн авч ажиллаж байна. Байгууллага нь улирал бүр ард иргэдээс үйл ажиллагааны талаарх санал хүсэлт, мөн цаашид хийх шинэлэг ажлын саналыг авч ажилладаг. 2018 онд нийт 3 удаа 164 иргэнээс санал асуулга авч цаашид анхаарах болон хийх ажлыг сар бүрийн ажлын төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлэн ажиллаж байна. Иргэдээс ирсэн саналын 80-с дээш хувийг “шинэ барилгатай болох” гэсэн санал эзлэж байна.	
2.7	Бүртгэл хяналтад байх эрх зүйн актын жагсаалтыг гарган хэрэгжилтийг хагас, бүтэн жилээр ЗГ-ын 2013 оны 322 тогтоолын 6 хавсралтын дагуу Төрийн захиргааны удирдлагын хэлтэст тооцон ирүүлж байх	Энэ онд УИХ-ын 1 тогтоол, УИХ-ын байнгын хорооны 1 тогтоол, ерөнхийлөгчийн зарлиг 1, ЗГ-ын тогтоол 8, ерөнхий сайдын захирамж 1, ЗГ-ын хуралдааны тэмдэглэл 3, ЗГ-ын албан даалгавар 1, ЗГХЭГ-ын даргын тушаал 1 нийт 17 тогтоол шийдвэрийн 51 заалтыг бүртгэл хяналтад авч тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг хагас бүтэн жилээр хэрэгжилтийг тооцож аймгийн ЗДТГ-ын ТЗУХ-т хүргүүлсэн ба тогтоол шийдвэрийн хэрэгжилт 93,3 хувьтай байна.	100
2.8	Багийн Засаг дарга нартай үр дүнгийн гэрээ байгуулан ажлыг идэвхжүүлэн шинэлэг ажил өрнүүлэх, ажлын тайланг улирал бүр тавиулж, хийсэн ажлын мэдээ, мэдээллийг олон нийтэд ил тод мэдээлж хэвших	Багийн дарга нартай үр дүнгийн гэрээ, ёс зүй хариуцлагын гэрээг байгуулсан. Багийн Засаг дарга нар багийн иргэдийн талаарх бүх төрлийн судалгаатай болсон. Иргэд малчдад зар, мэдээ мэдээллийг цаг тухай бүр хүргэж ажиллалаа. ЗДТГ-аас 4 сарын 18-нд нээлттэй хаалганы өдөрлөг зохион байгуулж багийн Засаг дарга нар 1-р улиралд хийсэн ажлын тайлангаа танилцуулсан. 6 сарын 15-16-нд болох 4 багийн нэгдсэн өдөрлөгөөр багийн дарга нар 2018 оны хагас жилийн ажлын тайлангаа танилцуулж ажилласан. Мөн 9 сард багийн иргэдийн нийтийн хурал, багийн өдөрлөгийг баг тус бүртээ хийж сумын удирдлагууд болон мэргэжилтнүүд оролцож мэдээлэл хийж ажилласан. 12 сарын 7-нд жилийн эцсийн хүн ам, мал тооллогын	100

		ажлаар багийн нийт айл өрхөөр орж сум орон нутгаас хийж хэрэгжүүлсэн ажлын талаар мэдээлж ажилласан.	
2.9	Гадаад хамтын ажиллагааг орон нутагт хөгжүүлэхэд санаачлага гарган, холбогдох хууль тогтоомжийн дагуу ажиллах	Сумын Засаг даргын орлогч Н.Өнөржаргал 2018 оны 5 сарын 7-14-ний өдрүүдэд Хонконг, Макао улсуудын их сургууль, үйлдвэржилтийн байдалтай танилцаж ажиллаад ирсэн.	100
2.1 0	Сумын гамшгаас хамгаалах төлөвлөгөөг тодотгон, санг нэмэгдүүлж, гамшгаас урьдчилан сэргийлэх, тэмцэх чиглэлээр бүтээлч ажил хийсэн байх	Сумын гамшгаас хамгаалах төлөвлөгөөг 1-р сард тодотгож мэргэжлийн ангийн бие бүрэлдэхүүнийг тодотгосон. 3 сарын 29-нд зардан мэдээллийн дохиогоор ажиллах журмын дагуу серень дохиог ажлуулж сургалтанд 82 иргэн 8 машин техник хамрагдсан. 5 сарын 8-9-нд аймгийн Онцгой байдлын газраас гамшгаас хамгаалах бэлэн байдлын үзлэг зохион байгуулж үзлэгт сумын мэргэжлийн анги бүрэн оролцож, багаж техник хэрэгслийн бэлэн байдлаа хангаж ажилласан.	100
Хөтөлбөр -3. Батлан хамгаалах бодлогыг орон нутагт хэрэгжүүлэх			
3.1	Дайчилгааны төлөвлөгөөг хэрэгжүүлэх бодит нөхцөлийг бүрдүүлэх, тайван ба дайны үед хүн амын зайлшгүй хэрэгцээнд шаардагдах гол нэр төрлийн материал хэрэгслийн нөөцийг бүрдүүлж, түүнийг шинэчлэх, нөхөн сэлбэх, хадгалалт, хамгаалалтыг зохион байгуулах, биелэлтэнд хяналт тавих /Батлан хамгаалах тухай хуулийн 17.1.5, 17.1.7, Дайчилгааны тухай хуулийн 16 дугаар зүйл/	Сумын дайчилгааны төлөвлөгөөг тодотгож оногдуулан данслалтыг хийлсэн. 2 дугаар зэргийн бэлтгэл үүрэгтний бэлтгэл сургуулилтанд 2 төрийн албан хаагч Өмнөговь аймгийн ЗХ-ний 167-р ангид сургалтанд хамрагдсан.	100
3.2	Цэргийн бүртгэлийг зохион байгуулан явуулах хөтлөх, / Батлан хамгаалах тухай хуулийн 17.1, Цэргийн албаны тухай хуулийн 34 дүгээр зүйл/	2018 оны цэргийн тоо бүртгэлийг 1-р сард зохион байгуулж тайлан мэдээ, судалгааг хугацаанд нь хүргүүлж ажилласан.	100
3.3	Цэрэг татах, цэргийн албанд гэрээгээр элсүүлэх ажлыг зохион байгуулах; / Батлан хамгаалах тухай хуулийн 17.1, Цэргийн албаны тухай хуулийн 34 дүгээр зүйл/ Сум орон нутагтаа цэргийн насны иргэнийг эрүүлжүүлэх, боловсролыг дээшлүүлэх ажлыг зохион байгуулах. / Батлан хамгаалах тухай хуулийн 17.1.12/	Цэргийн насны иргэнийг эрүүлжүүлэхэд анхаарч цэрэг татлагаар эрүүл мэндийн байдлаас болж чөлөөлөгддөг 8 иргэний судалгааг аймгийн Цэргийн штабт гаргаж хүргүүлсэн. сумын ЭМТ дээрх 8 иргэнийг эрүүлжүүлэх арга хэмжээ авч баг, сумын эмчийн хяналтанд байлгаж жилд 2-3 удаа эрүүл мэндийн үзлэгт оруулж сумын эмнэлэгт 3 иргэнийг, аймгийн эмнэлэгт 1 иргэнийг тус тус хэвтэн эмчлүүлж, 1 иргэнийг 2-р шатлалын эмнэлэгт нарийн мэргэжлийн үзлэг шинжилгээнд хамруулсан байна. 2018 оны 2 дугаар ээлжийн цэрэг татлагат 28 цэрэг цэрэг татлагын товчоогоор орж 8 залуу 4 нь УИХ-ын 33-р тогтоолоор чөлөөлөгдөж 4 нь мөнгөн төлбөр төлж чөлөөлөгдсөн байна. Тус сумаас 1 цэрэг 0167-р ангид алба хааж байна. Цэргийн насны залуучуудын боловсролыг дээшлүүлэх чиглэлээр НТБ-ын нэгжийн багш Н.Оюунцэцэг 10 сард цэрэг татлагын товчоогоор орох 28 залуучуудад цэрэг, эх оронч үзлийн талаар, ЗДТГ-ын дарга цэргийн албаны тухай хуулиар сургалт мэдээлэл хийж ажилласан.	100
3.4	Батлан хамгаалах хууль тогтоомжийн хэрэгжилтийг зохион байгуулах; /Батлан хамгаалах тухай хуулийн 17.1.1/	2018 оны цэргийн шинэчилсэн тоо бүртгэлийн үеэр цэргийн насанд хүрч буй залуучуудад, 10 сард цэрэг татлагын товчоогоор орох 28 иргэнд цэргийн албаны тухай хуулийг тайлбарлан ойлгуулж, уг хуулиар гарын авлагыг бэлтгэн өгсөн. Мөн 2 иргэнийг 2 дугаар зэргийн бэлтгэл үүрэгтний сургалтанд хамруулсан байна.	100

	Батлан хамгаалах асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад шаардлагатай мэдээ, мэдээлэл, судалгааг гаргаж өгөх; / Батлан хамгаалах тухай хуулийн 17.1.9/	Аймгийн Цэргийн штабаас ирүүлсэн мэдээ судалгааг цаг хугацаанд нь хүргэж ажилласан. 2018 оны 2-р ээлжийн цэрэг татлагаар	
3.5	Дүйцүүлэн хаалгах ажлыг зохион байгуулах; / Батлан хамгаалах тухай хуулийн 17.1, Цэргийн албаны тухай хуулийн 34 дүгээр зүйл/	Тус суманд дүйцүүлэхээр алба хааж байгаа иргэн байхгүй.	100
3.6	Орон нутгийн хамгаалалтыг төлөвлөх, зохион байгуулах, хэрэгжүүлэх, нутаг дэвсгэрийнхээ дэд бүтцийг орон нутгийн хамгаалалтын зорилготой уялдуулан хөгжүүлэх;/Батлан хамгаалах тухай хуулийн 17.1.2, 17.1.3/	Хэрэгжих боломжгүй.	
3.7	Иргэд /хүүхэд/ эх оронч үзэл, хүмүүжил, үндэсний бахархал, уламжлалыг төлөвшүүлэх, боловсрол, оюун санаа, бие бялдрыг хөгжүүлэх ажлыг зохион байгуулах; Батлан хамгаалах тухай тухай хуулийн 17.1.10/	2018 оны цэргийн шинэчилсэн тоо бүртгэлийн үеэр цэргийн насанд хүрч буй залуучуудад, 10 сард цэрэг татлагын товчоогоор орох 28 иргэнд цэргийн албаны тухай хуулийг тайлбарлан ойлгуулж, уг хуулиар гарын авлагыг бэлтгэн өгсөн. НТБ-ын нэгжийн багш Н.Оюунцэцэг цэрэг татлагын товчоогоор орох залуучуудад цэрэг, эх оронч үзлийн талаар сургалт хийсэн. 2018 оны 05 сарын 26-нд Байгаль орчинд бидний оролцоо анхдугаар чуулганыг аймагт зохион байгуулж сумын эко клубын багш Д.Амармэнд, сурагч О.Мөнхжин, М.Эрдэнэзул, Д.Шинэбаяр, Б.Сэржхандам, Д.Өсөх-эрдэнэ, Г.Чимэдхорол нар оролцож ногоон паспорт аянд нэгдлээ. Мөн цэцэрлэг, сургуулийн нийт 80 гаруй хүүхдүүдээс бие бялдрын чийрэгжилийн сорилыг авсан.	100
ҮНЭЛГЭЭНИЙ ДУНДАЖ			92,7%

ТӨРИЙН ЗАХИРГАА, УДИРДЛАГЫН ХЭЛТЭС


**Аймгийн Засаг даргаас сумын Засаг даргатай байгуулах
үр дүнгийн гэрээний 5 дугаар хавсралт**

**Хөдөө аж ахуй, үйлдвэрлэл үйлчилгээ, хүнс худалдаа, байгаль орчин, аялал
жуулчлал, ашигт малтмал, уул уурхай, хөрөнгө оруулалт, дэд бүтцийн
хүрээний хөтөлбөр, ажил, арга хэмжээ**

№	Зорилт, хэрэгжүүлэх ажил, хөтөлбөр, арга хэмжээ	Хэрэгжилт	Хувь
1. Хөдөө аж ахуйн бодлогын хүрээнд:			
1.1	Малын генетик нөөцийн тухай хууль, Мал амьтны эрүүл мэндийн тухай хууль хэрэгжиж эхлэхтэй холбогдуулан сумын МҮЭНэгжийн бүтэц, орон тоо, өөрчлөлтүүдийг журмын дагуу дагаж мөрдөх	6-р сарын 14-нд Малын генетик нөөцийн тухай хууль, Мал амьтны эрүүл мэндийн тухай хуулийн бүсчилсэн сургалт Говь-Угтаал суманд болж уг сургалтанд ХХААХҮЯамны бодлого, төлөвлөлтийн газрын мал эмнэлгийн бодлогын асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн Х.Алтангэрэл оролцож мэдээлэл хийлээ. 2018 оны 9-р сарын 13-нд Канадын хоршоодын холбоо, Монголын хоршооллын сургалт мэдээллийн төвийн “Инвест ко-оп Монгол” төслийн ажилтан Энхтөр багийн Засаг дарга нар, малдчын төлөөлөл, албан хаагчдад 2017.12.08-нд батлагдаж 2018 оны 6-р сарын 1-ээс эхлэн мөрдөгдөж байгаа “Мал амьтны эрүүл мэндийн тухай” хууль, “Малын генетик нөөцийн тухай” хуулиудын талаарх мэдээллийг өглөө. Багийн нэгдсэн өдөрлөгөөр Малын генетик нөөцийн тухай хууль, Мал амьтны эрүүл мэндийн тухай хуулиудаар мэдээлэл хийсэн. Сургалтанд 100 иргэн хамрагдсан. 	100
1.2	Сумын бэлчээрийн менежментийн төлөвлөгөөтэй болж доройтол талхлагдалтаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа зохион байгуулах	Сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөө батлагдах шатандаа явж байна. 2018 оны 11 сарын 29-нд аймгийн бэлчээр ашиглах журмын хэлэлцүүлэг болж сумын орлогч дарга оролцсон. Хэлэлцүүлгээр бэлчээр ашиглах журмын төсөлд санал авч аймгийн ИТХ-аар батлуулахаар шийдвэрлэсэн. Дээрх төлөвлөгөө, журам батлагдахаар сумын бэлчээрийн менежментийн төлөвлөгөөг боловсруулж батлуулах арга хэмжээ авч ажиллахаар төлөвлөөд байна.	70%
1.3	Гүн өрмийн худгийг шинээр гаргах болон сэргээн засварлах, энгийн уурхайн худгийг сэргээн засварлаж усан хангамжийг нэмэгдүүлнэ.	Багуудад энгийн уурхайн худаг засварлан тохижуулахаар ОНХС-ийн 5,7 сая төгрөгийн төсвийг батлуулсан. Сумын төвд “Манна хөгжил” ТББ-ын 100 хувийн хөрөнгө оруулалтаар гүн өрмийн худаг гаргасан бөгөөд 4-р багт 2 бүлэг тус бүр 1 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар энгийн уурхайн худаг сэргээн засварлаад байна. 2018 оныг бүтээн байгуулалтын жил болгож иргэд, албан байгууллагуудын дунд уралдаан зарлаж 1-р багийн иргэн П.Бурмаа хувийн хэрэгцээнд 6 сая төгрөгөөр гүн өрмийн худаг гаргасан. 	100

1.4	Малын халдварт, гоц халдварт, шимэгчтэх өвчнөөс урьдчилан сэргийлэх, мал сүргийг эрүүлжүүлэх, тэмцэх арга хэмжээг зохион байгуулж, хэрэгжүүлэх	Малын гоц халдварт Шүлхий өвчин гарсны улмаас 4650 үхэрт давтан тарилтаар 2 удаа, 362 тэмээ, эрүүл бүсийн 11288 хонь, 8810 ямаа нийт 25110 малын урьдчилан сэргийлэх вакцинд хамруулсан байна. Шөвөг яраас сэргийлэх вакциныг 79 өрхийн хурга 7078, ишиг 11344 нийт 18422 төлд хийгээд байна. Цусан халдвартын вакцинд 3960 бог, Дотрын халдварт хордлогын вакцинд 4104 бог мал, Шүлхийн вакцин 3326 үхэрт, Бруцеллёзын вакцинд тугал 231, хурга, ишиг 31672 төл хамруулсан байна. Туулгалтанд хонь 8750, ямаа 3636, угаалга 13580 мал угаалганд хамруулсан.	100
1.5	Мал аж ахуй, төв суурин газрын өвөлжилт, хаваржилтын бэлтгэл ажлыг хангах аймгийн Засаг даргын албан даалгаврыг хэрэгжүүлэх сумын ажлын хэсэг байгуулах, аймгийн нэгдсэн төлөвлөгөөг үндэслэн сумын төлөвлөгөөг хэрэгжүүлж, дүгнүүлэх	Сумын Засаг даргын 2018 оны 08-р сарын 02-ний А/65 тоот захирамжаар мал аж ахуйн болон төв суурингийн 2018-2019 өвөлжилтийн бэлтгэл хангах 16 заалттай ажлын төлөвлөгөөг гаргаж өвөлжилтийн бэлтгэл 81.3%-тай дүгнэгдсэн. Сумын өвс, тэжээлийн аюулгүйн нөөцөд 8.3 тн өвс, 11.8 тн тэжээлийн нөөцийг бүрдүүлээд байна. Малчид өвс 167.2 тн, тэжээл 100.1 тн, гар тэжээл 64 тн-ыг бэлтгээд байна. Малчдад малын хашаа, саравч, уст цэгээ засварлах, тохижуулах, түлш бэлтгэх, цаг агаар хүндэрсэн нөхцөлд хэрэглэх өвс, тэжээл, гар тэжээлийг нөөцлөх, өвлийн хувцас хэрэглэл, хоол хүнсний нөөц бүрдүүлэх зэргээр хувийн бэлтгэлийг сайтар хангах талаар сумын Засаг даргын албан даалгаврыг 165 малчин өрхөд өгсөн.	100%
1.6	Тухайн оны өвс, тэжээлийн аюулгүй нөөц бүрдүүлэх, шаардагдах санхүүгийн эх үүсвэрийг шийдвэрлэх	Сумын өвс, тэжээлийн аюулгүйн нөөцийг агуулахыг 8 сая төгрөгөөр бариад байгаа бөгөөд ЗГ-ын тогтоолын дагуу өвс, тэжээлийн аюулгүйн нөөцөд 28.3 тн өвс, 11.8 тн тэжээлийн нөөцийг бүрдүүлээд байгаа бөгөөд 2.1 сая төгрөгийг зарцуулаад байна. 	100%
1.7	Улс, аймгийн аварга малчнаар шалгаруулахаар тодорхойлсон малчдын материалын бүрдлийг журмын дагуу хангах ажлыг хариуцлагатай зохион байгуулах	Тус сумаас ажил хөдөлмөр, мал маллах арга туршлагаар бусдыгаа манлайлж байгаа 2-р багийн малчин Б.Батсуурь, 1-р багийн малчин Д.Жаргалсайхан, Ж.Оросоо нарын материалыг аймгийн аварга малчин шалгаруулах журмын дагуу явуулж Б.Батсуурь, Д.Жаргалсайхан нар нь аймгийн аварга малчны болзол хангаж аймгийн аварга малчин болсон. “Улсын Аварга малчин”-д 4-р багийн аймгийн Аварга малчин Д.Сайнбаярын материалыг журмын дагуу хугацаанд нь явуулаад байна.	100%
2. Үйлдвэрлэл үйлчилгээ, хүнс худалдааны хүрээнд:			
2.1	“Эрүүл хүнс – Эрүүл Монгол хүн” үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх, “Мах, сүүний анхдугаар аян”-ы хүн амыг эрүүл, аюулгүй хүнсний бүтээгдэхүүнээр хангах ажлыг зохион байгуулах	ЕБС-ийн дотуур байрны хүүхдийн хоолны махны хэрэгцээг 1-р багийн малчин Х.Мөнхбаттай гэрээ байгуулан нийлүүлж 2018 онд 705 кг мах хэрэглээд байна. Цэцэрлэгийн хүүхдийн хоолны махны хэрэгцээг 4-р багийн малчин Т.Түмэннасттай гэрээ байгуулан нийлүүлж байгаа бөгөөд 1254 кг мах хэрэглээд байна.	70%
2.2	Сум хөгжүүлэх сангаар олгож байгаа зээлийн уялдаа холбоог сайжруулах, хэрэгжилтэнд хяналт тавих, хугацаа хэтэрсэн чанаргүй зээлийг шийдвэрлүүлж мэдээ тайланг хагас, бүтэн жилээр авч тайлагнах	Засгийн газрын 2016 оны 153 дугаар тогтоолын дагуу “Сум хөгжүүлэх сан”-гийн журмын хэрэгжилт үйл ажиллагаанд Хяналтын зөвлөлийн дарга Г.Дэмбэрэлжав, нарийн бичгийн дарга Ж.Чулуунтогтох нарын хамт 1 удаа шалгалт хийж зээл, зээлийн хүү төлөх талаар хугацаатай албан мэдэгдэл хүн тус бүрт хүргэн гарын үсэг зуруулан хүлээлгэн өгч ажиллалаа. Мөн сар тутам зээлдэгч нартай 2-оос доошгүй удаа утсаар ярьж анхааруулан ажиллаж байна. Хяналт шалгалтын арга хэмжээг зохион байгуулсаны үр дүнд 13 иргэн, 2 ААН-ийн үндсэн зээл 26.016.725 төгрөг, зээлийн хүү 2.603.341 төгрөг бүгд	100

		28.620.066 төгрөгийг “Сум хөгжүүлэх сан”-д төвлөрүүлэн ажилласан. Одоогоор СХС-д 15 иргэний зээл хэрэгжиж байгаагаас гадна 5 иргэн зээл, зээлийн хүүгээ бүрэн төлөн хэвийн үйл ажиллагаагаа явуулж байна. 2018 оны 12 сарын 1-ны байдлаар Сум хөгжүүлэх санд 43.518.758 төгрөг төвлөрсөн байна. Сум хөгжүүлэх сангаас программ шинэчлэн суулгасны төлбөрт 750.000 төгрөг, шуудан холбоонд 120.000 төгрөг, бичиг хэргийн зардалд 90.000 төгрөг буюу 960.000 төгрөгийн зардал гарч дансны үлдэгдэл 133.112.520 төгрөг байна. 2017 онд Аундтын байгууллагаас сум хөгжүүлэх сангийн өр авлага 75134256 төгрөгийн акт тавигдснаас хугацаа хэтрэлттэй өр авлага 52314341 төгрөгийн өр барагдуулан ажиллаж, үлдэгдэл 22819915 төгрөгийн хэтрэлт байгаагаас шүүхэд 2 иргэний 11634250 төгрөгийн өрийг барагдуулахаар явуулсан байна. Одоо зээлийн хэтрэлт 11185665 төгрөгийн өртэй байна. Өр барагдуулалт 85,1 хувь байна.	
2.3	“Дундговь түншлэл 2018” болон гойд ашиг шимт малын үзэсгэлэн худалдаа зохион байгуулж, бүс, улсын болон олон улсын үзэсгэлэн худалдаанд оролцогчдод дэмжлэг үзүүлнэ.	2018.10.04-05-ны өдрүүдэд Залуу малчдын зөвлөгөөнд тус сумаас 15 залуу малчин оролцсон. Энэ үеэр “Дундговь түншлэл-2018” үзсгэлэн худалдаа зохион байгуулагдаж 4-р багийн иргэн А.Эрдэнэчимэг, П.Сугирсүрэн нар хөхүүр, суран эдлэл, 2-р багийн малчин Х.Цэдэгсүрэн, Б.Батбаяр, Н.Алтанхуяг, Д.Мягмардорж нар айргаар үзэсгэлэн худалдаанд оролцов. Аймгийн хэмжээнд зохион байгуулагдсан үйл ажиллагаанд сайн зохион байгууллалттай оролцсон 5 сумын нэгээр шалгарч талархал хүлээн авч нийт дүнгээр 4-р байр эзэлсэн амжилт гаргалаа.	100
2.4	Сүү сүүн бүтээгдэхүүн, мах махан бүтээгдэхүүн, барилгын материал, мод модон бүтээгдэхүүн, малын гаралтай түүхий эд боловсруулах үйлдвэр байгуулах санал санаачлагыг түлхүү дэмжинэ.	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас олгох жижиг зээлийн төсөлд мод модон эдлэлийн төрлөөр үйл ажиллагаа явуулахаар 2 иргэн хамрагдаж гурвалсан гэрээ байгуулан 20000.0 төгрөгийн санхүүжилт аван үйл ажиллагаагаа явуулж байна.	70
2.5	Аймгийн аварга тогооч, худалдагч шалгаруулах ур чадварын уралдааныг зохион байгуулж үйлчилгээний байгууллагын чанар хүртээмжийг нэмэгдүүлнэ.	Аймгийн аварга тогоочийн уралдаан 10-р сарын 5-6-ны өдрүүдэд зохион байгуулагдаж уг уралдаанд сум орон нутгаа төлөөлж Ерөнхий боловсролын сургуулийн дотуур байрны тогооч Р.Намсрайсүрэн амжилттай оролцлоо.	100
2.6	Хүн амын хүнсний хангамжийг тогтворжуулах, стратегийн хүнсний нийлүүлэлтийн улирлын хамаарлыг бууруулах зорилгоор “Мах, сүүний анхдугаар аян”-ыг зохион байгуулж, хүн амыг эрүүл, аюулгүй бүтээгдэхүүнээр хангана.	ЕБС-ийн дотуур байрны хүүхдийн хоолны махны хэрэгцээг 1-р багийн малчин Х.Мөнхбаттай гэрээ байгуулан нийлүүлж байна. Хагас жилийн байдлаар 400 кг мах хэрэглээд байна. Цэцэрлэгийн хүүхдийн хоолны махны хэрэгцээг 4-р багийн малчин Т.Түмэннасттай гэрээ байгуулан нийлүүлж байгаа бөгөөд 530 кг мах хэрэглээд байна.	70%
3. Байгаль орчин, аялал жуулчлал, ашигт малтмал, уул уурхайн хүрээнд:			
3.1	Сум бүр 1-ээс доошгүй га талбайд мод тарьж, ногоон байгууламжийн хэмжээг нэмэгдүүлэх	Ногоон зурвас байгуулах ажлын хүрээнд 2018 оны 05 сарын 02-нд аймгийн Байгаль орчин аялал жуулчлалын газарт 200 улиас, 200 хайлаас, 100 шар хуайс, 100 агч модыг авчирч сумын албан байгууллага аж ахуй нэгжүүд 600 мод тарьсан байна. Мөн сургууль, цэцэрлэг үхрийн нүд, шар хуайс 80 модыг хүүхдүүдийн хамт тарьсан. Нийт сумын хэмжээнд 680 мод тарьлаа. 2018 оны 05 сарын 21-нд 4-р багийн иргэн Ц.Мөнгөнчимэгтэй мод услах гэрээ хийж усалгааг тогтмол хийсэн.	100%

3.2	Ногоон хэрэм хөтөлбөр, ойн зурвас байгуулах ажлын хүрээнд аймаг, сумдын төвд шинээр өргөтгөх, засмал замын дагуу байгууллага, аж ахуйн нэгж, иргэдээр мод тариулна.	Ногоон хэрэм хөтөлбөр, ойн зурвас байгуулах ажлын хүрээнд 2018 оны 05 сарын 02-нд аймгийн Байгаль орчин аялал жуулчлалын газарт 200 улиас, 200 хайлаас, 100 шар хуайс, 100 агч модыг авчирч тарьсан байна. Мөн сургууль, цэцэрлэг үхрийн нүд, шар хуайс, нийт сумын хэмжээнд 680 мод тарьлаа. Мод тарих ажилд сумын бүх төрийн байгууллагуудын ажилтан албан хаагчид оролцсон. 2018 оны 05 сарын 21-нд 4-р багийн иргэн Ц.Мөнгөнчимэгтэй мод услах гэрээ хийж усалгааг тогтмол хийсэн. Сумын төвд ногоон байгууламж ойн зурвас бий болгохоор цэцэрлэгт хүрээлэн байгуулах ажлыг эхлүүлж хүрээлэнгийн хашааг ОНХС-ийн 24 сая төгрөгийн хөрөнгөөр Цагаан толгой нуур ХХК хийж гүйцэтгэж байна.	70%
3.3	Эрдэнэдалай, Цагаандэлгэр, Өлзийт, сумдад цэцэрлэгт хүрээлэн байгуулах	Цэцэрлэгт хүрээлэнгийн зураг төсвийг Аслаан ХХК-аар 214,0 сая төгрөгийн зураг төсвийг хийлгэсэн. Сумын 2018 оны ОНХС-ийн 24 сая төгрөгөөр цэцэрлэгт хүрээлэнгийн хашаа барих ажлыг “Цагаан толгойн нуур” ХХК-тай гэрээ байгуулан гүйцэтгүүлж ажил удаашралтай явагдаж, гэрээнд заагдсан үүргээ биелүүлээгүй тул тус компаныг шүүхэд шилжүүлэх тухай албан тоотыг компаны удирдлагад хүргүүлсэн.	40
3.4	Аймгийн байгалийн ургамлын нэгдсэн судалгааг мэргэжлийн байгууллагаар хийлгэнэ.	Хамааралгүй заалт	-
3.5	Жуулчдад үзүүлэх уламжлалт зан заншил, нутгийн онцлогтой бүтээгдэхүүн, үйлчилгээг өргөжүүлэх	Энэ онд “Орон нутаг судлах танхим”-ын эхлэлийг тавьж, улсын төсвийн 700.000 төгрөгөөр засвар, тохижилтын ажлыг хамт олныхоо хүчээр хийж нийт 42 дэсийн 207 ширхэг үзмэрийг дэлгэж, 200 гаруй иргэдэд үйлчилгээг хүргээд байна. Энэ онд 5 төрлөөр үзэсгэлэн гаргаж давхардсан тоогоор нийт 200 гаруй иргэд хамрагдлаа. Сумын баяр наадам болон аймгийн тахилгат Баян уул хайрханы тахилга наадмаар “Соёлын гэр”-ийг барьж  ОНСТанхимын үзмэрээр үзэсгэлэн гаргаж ард иргэдэд сурталчиллаа.  ОНСТанхим нь “Ёс заншил”, “Дуу хуур”, “Түүхийн дурсгалт газар” гэсэн булан байгуулж мэдээ мэдээллийг сар бүр баяжуулан ажиллаж байна. Ёс заншилийн буланг танин мэдэхүй, монгол ёс, монгол наадгай гэсэн 3 төрөл мөн дуу хуурийн буланд шинэ танил, мэдээ-мэдээлэл, соёл урлаг гэсэн нийт 27 мэдээллээр баяжилт хийсэн байна. ЕБСургуулийн сурагчдийн дунд “Чулуун наадгай” чулуун бүтээлийн уралдаан зарлаж 13 сурагчийн бүтээл ирсэнээс 1-р байрыг М.Хурхарцага дэд байрыг М.Эрдэнэзул гутгаар байрыг Д.Шинэбаяр нар тус тус эзэллээ. Танхимын үзмэр эд өлгийн зүйлийн тоо төрлийг нэмэгдүүлэх зорилгоор байгууллагийн ажилчдын дунд сарын хугацаатай уралдаан зарлаж 5 ширхэг үзмэрээр баяжилт хийлээ. Үүнд шашин шүтлэгийн холбогдолтой 2, угсаатан зүйн холбогдолтой 3 үзмэр нэмэгдлээ. Уралдааны 1-р байрыг бүжгийн багш Э.Дорждэрэм дэд байрыг үйлчлэгч Ц.Мөнгөнчимэг нар эзэллээ. Дундговь аймагт зохион байгуулдагсан СББӨ-ийн наадамд үзэсгэлэнгийн төрлөөр амжилттай оролцож 2-р байр, Улаанбаатар хотод зохион байгууландсан “Нүүдэлчин монгол” Соёлын биет бус өвийн ардын урлагийн их наадамд “Намар” цагийн өргөөг	100

		тохижуулж амжилттай оролцлоо. Жил бүр “Нээлттэй хаалганы өдөрлөг”-өөр үзмэрийн үзэсгэлэг гаргаж хэвшсэн байна.	
3.6	Тухайн сумын нутагт үйл ажиллагаа явуулж буй жуулчны бааз, амралтын газар, гэр буудал, дэн буудал, малчин өрхийн судалгааг тогтмол гаргаж холбогдох газарт хүргүүлж байх	Тус суманд үйл ажиллагаа явуулдаг жуулчны бааз, амралтын газар, дэн буудал байхгүй. 252 малчин өрхийн судалгааг гаргаж хүргүүлсэн.	100
3.7	Малчдын уламжлалт аргаар боловсруулан үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнийг жуулчдад борлуулан амьжиргаа дээшлүүлэхэд дэмжлэг үзүүлэх	2018.10 сард “Дундговь түншлэл-2018” үзсгэлэн худалдаа зохион байгуулагдаж 4-р багийн иргэн А.Эрдэнэчимэг, П.Сугирсүрэн нар хөхүүр, суран эдлэл, 2-р багийн малчин Х.Цэдэгсүрэн, Б.Батбаяр, Н.Алтанхуяг, Д.Мягмардорж нар айргаар үзэсгэлэн худалдаанд оролцож хийсэн бүтээл, бүтээгдэхүүнээ зарж борлуулсан. 1 хөхүүр 450,0 төг, 21 бугуйл 150,0 төг, айраг 360 литр айраг 1800,0 төгрөг нийт 2400,0 төгрөгний борлуулалт хийж 200 литр айрагны захиалга авч нийлүүлсэн.	70
3.8	Аймаг орон нутгийн тусгай хамгаалалтанд авах газар нутгийн холбогдох шатны Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар батлуулах.	Санал ирээгүй.	100
3.9	Тусгай хамгаалалттай газар нутгийн мэдээллийн санг бүрдүүлж, эрхзүйн хувьд чадамжгүй тогтоолыг шинэчилж, цэгийн давхцыг арилгах ажил зохион байгуулах	Хэрэгжээгүй.	0
3.10	Иргэд, олон нийтэд экологийн боловсрол олгох байгаль орчныг хамгаалахын ач холбогдлыг сурталчилах.	2018 оны 3 сарын 22-нд дэлхийн усны өдөрт зориулж ерөнхий боловсролын сургуулийн 5-9-р ангийн хүүхдүүдэд 2018 оны 03 сарын 21-нд ус, байгаль орчны талаар мэдээлэл өгч гарын авлага тарааж 3 сарын 22 -нд хөгжөөнт цэнгээнт АХА тэмцээнийг зохион байгуулж Б.Сугирсүрэн, Б.Сэржхандам, М.Анужин нар 1,2,3-р байрыг эзэлсэн. Мөн 1-4-р ангийн хүүхдүүдийн дунд "Ус чандмань эрдэнэ" сэдэвтэй зургийн уралдаан зарлаж нийт 29 зураг ирснээс С.Сүхзориг, Б.Бадар-Ууган, А.Ариунжаргал нар 1,2,3-р байр эзэлж тусгай байранд М.Тэмүжин орж тус бүр өргөмжлөл, дурсгалын зүйлээр шагналаа. 2018 оны 05 сарын 26-нд Байгаль орчинд бидний оролцоо анхдугаар чуулганыг аймагт зохион байгуулж сумын эко клубын багш Д.Амармэнд, сурагч О.Мөнхжин, М.Эрдэнэзул, Д.Шинэбаяр, Б.Сэржхандам, Д.Өсөх-эрдэнэ, Г.Чимэдхорол нар оролцож ногоон паспорт аянд нэгдлээ.	100
4. Дэд бүтэц, хөрөнгө оруулалт, худалдан авах ажиллагаа, өмчийн бодлого зохицуулалтын хүрээнд:			
4.1	Батлагдсан хаягийн зургийн дагуу сумын төвийн хаягийн тэмдгийг суурилуулах ажлыг зохион байгуулах	Сумын төвийн хаягжуулалт хийх ажлыг Вектор меп ХХК ОНХС-ийн 4,2 сая төгрөгөөр хийж гүйцэтгэн хүлээлгэн өгсөн.	100
4.2	Сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөөг боловсруулах, батлуулах	Сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг хийлгүүлэхээр аймгийн ГХБХБГ-тай хамтран Вектор Мэп ХХК-тай 5 сард гэрээ байгуулж ажлын хэсэг 7 сард ирж судалгааны ажлаа хийж 11 сард аймгийн төвд нэгдсэн хэлэлцүүлэгт хийж сумын Засаг дарга Д.Буджав нэмж хэд	100

		хэдэн саналыг тусгасан. Сумын 2018 оны ОНХС-д батлагдсан 5 сая төгрөгийг олгож одоо 10 сая төгрөгийг олгох дутуу байна. 2018.12.18-ны сумын ИТХ-ын ээлжит 6-р хуралдаанаар сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөө батлагдан гарах юм.	
4.3	Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдэх ажлыг сумын хөгжлийн бодлоготой уялдуулан төлөвлөж хууль журмын дагуу иргэдээс санал авч эрэмбэлж батлуулах	2018 оны ОНХС-ийн хөрөнгөөр хийгдэх ажлын саналыг 2017 оны 2-р улиралд багтаан иргэдээс санал авч эрэмбэлж жагсаалтыг 2017 оны 12 сард сумын ИТХ-ын хуралдаанаар хэлэлцүүлж 83066400 төгрөгийг батлуулсан. Үүний дагуу сумын Засаг дарга 2018 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг баталсан. Төлөвлөгөөний дагуу 13 төсөл арга хэмжээний 9 ажил арга хэмжээг зохион байгуулсан байна.	70
4.4	Улсын болон орон нутгийн хөрөнгө оруулалтаар хийгдэх ажил болон сургуулийн үдийн хоол, цэцэрлэгийн хоол хүнсний материалыг нийлүүлэгчийн сонгон шалгаруулалтыг цахим системээр зарлах	Сургуулийн үдийн хоолны хүнсний материалыг “Сирина” ХХК-тай шууд гэрээ байгуулан нийлүүлж байна. Цэцэрлэгийн хоол хүнсний материал нийлүүлэгчийг худалдан авах ажиллагааны сертификаттай хүн байхгүй учир тендер зарлагдаагүй.	70
4.5	Тендер шалгаруулалтыг хууль тогтоомжийн дагуу зохион байгуулж, ажлын гүйцэтгэлд хяналт тавьж ажиллах	Тендер шалгаруулалт худалдан авах ажиллагааг Төрийн болон орон нутгийн өмчөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль, Төсвийн тухай хууль болон орон нутгийн хөгжлийн сангийн журмын дагуу хууль тогтоомжид нийцүүлэн зохион байгуулж ажилласан.	70
4.6	Хөрөнгө оруулалтаар хийгдэж буй ажлыг хүлээн авч, тайлан мэдээг тухай бүр ирүүлж байх, барилга байгууламж, тоног төхөөрөмж, машин механизмыг орон нутгийн өмчид бүртгэж тайлан балансад тусгах	Энэ онд орон нутгийн хөгжлийн сан, улсын төсөв, байгууллагын хөрөнгөөр өвс тэжээлийн нөөцийн агуулахыг 8 сая төгрөгөөр барьсан. ЗДТГ-ын төсвийн хөрөнгө оруулалтаар 4 сая төгрөгний зөөврийн компьютер, суурин компьютер, принтер худалдан авсан. Хөдөө аж ахуйн газраас 2760000 төгрөгний үлийн цөмлөгч 2, ухагч багаж 6 ширхэгийг авсан. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар мал угаалгын зөөврийн ванн /1366600/ зэрэг эд хөрөнгийг Засаг даргын тамгын газрын барилга байгууламж, машин тоног төхөөрөмж, аж ахуй материал дээр бүртгэх саналыг сумын өмч хамгаалах зөвлөлд материаллаа өгсөн.	100
4.7	Сумдад ашиглагдахгүй илүүдэлтэй байгаа эд хөрөнгийн ашиглалтыг сайжруулах, эдийн засгийн эргэлтэнд оруулах, худалдан борлуулах талаар шат шатны арга хэмжээг шуурхай авч ажиллах.	Суманд ашиглагдахгүй байгаа хуучин холбооны барилгыг сумын Уяачдын холбоонд шилжүүлсэн. Мөн хуучин өвсний агуулахын зориулалтаар ашиглаж байсан барилгыг Ган-илч ХХК-д эзэмжүүлж байна. ЗДТГ-ын ашиглах боломжгүй 5 орон сууцыг үнэ бууруулан худалдахаар хөндлөнгийн үнэлгээчнээр үнэлүүлж үнэлгээг тогтоон сумын өмч хамгаалах комисст хүргүүлсэн.	100
ҮНЭЛГЭЭНИЙ ДУНДАЖ			85,1%

ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ, ХӨГЖЛИЙН БОДЛОГО ТӨЛӨВЛӨЛТИЙН ХЭЛТЭС

ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ХҮРЭЭНД ХЭРЭГЖҮҮЛЭХ
ХӨТӨЛБӨР АРГА ХЭМЖЭЭ

д/д	Хөтөлбөр арга хэмжээ	Хэрэгжилт	Хувь
Хөтөлбөр 1. Хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах, сурталчлах, шударга ёс, ил тод байдлыг эрхэмлэн авлига, хүнд сурталгүй төрийн үйлчилгээг хэрэгжүүлнэ.			
1.1	“Захиргааны ерөнхий хууль”-ийг хэрэгжүүлэх ажлыг удирдлага, зохицуулалтаар хангаж захиргааны хэм хэмжээ тогтоосон шийдвэрийг тус хуульд нийцүүлэн ирүүлэх, Хууль зүй дотоод хэргийн яаманд хянуулах, бүртгүүлнэ. /Захиргааны ерөнхий хуулийн 26, 27, 29, 59, 60, 61, 62, 64 дүгээр зүйл/	Захиргааны аливаа акт шийдвэр гаргахдаа тухайн шийдвэртэй холбоотой албан хаагчид нь урьдчилан мэдэгдэж ажиллаж байна. Захиргааны ерөнхий хуулийг үйл ажиллагаандаа мөрдөж зөрчил дутагдалгүй ажиллаж байна. Сумын Засаг даргын батлан гаргасан захирамжийг улирал бүр хянуулж байна.	100
1.2	Сумын Засаг даргын захирамж, шийдвэрийг төслийн шатанд хууль зүйн үндэслэлийг хангуулах, холбогдох мэргэжилтэн, иргэд, олон нийтийн санал, зөвлөмжийг тусгах, тэдний хяналт, оролцоог нэмэгдүүлэхэд чиглэсэн үйл ажиллагааг тогтмолжуулж, тодорхой журам, аргачлалд оруулж, ил тод сурталчилж хэрэгжүүлнэ.	Сумын Засаг даргын захирамж, шийдвэрийг төслийн шатанд нь хууль зүйн үндэслэлийг хянаж холбогдох мэргэжилтэн, иргэдийн санал, зөвлөмжийг тусгаж ажиллалаа.	100
1.3	“Бүх нийтийн эрх зүйн боловсрол” үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг удирдлага, зохион байгуулалтаар хангаж, сумын ЗДТГ-ын даргаар ахлуулсан “Эрх зүйн хөтөч” багийн үйл ажиллагааг эрчимжүүлж, дэмжлэг, тусалцаа үзүүлж, эрх зүйн сургалт, сурталчилгааны ажлыг нэгдсэн төлөвлөгөө, удирдамжийн дагуу үе шаттай зохион байгуулна.	“Бүх нийтийн эрх зүйн боловсрол” үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг сумын Засаг даргаар батлуулан ажиллаж байна. Мөн энэ хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд ЗДТГ-ын даргаар ахлуулсан “Эрх зүйн хөтөч” багийг шинэчлэн томилсон. Сумын эрх зүйн хөтөч багаас 2018 онд судлан сурталчлах хууль эрх зүйн актын төлөвлөгөөнд 21 хууль тогтоомжийг судлуулахаар төлөвлөсөн. Үүнээс 11 сарын эцсийн байдлаар 14 хууль тогтоомжийг төрийн албан хаагчдад танилцуулж давхардсан тоогоор 208, төлөвлөгөөнөөс гадна 9 удаагийн мэдээлэл сургалтанд давхардсан тоогоор 216 иргэд, төрийн албан хаагч хамрагдсан.	100
1.4	Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг орон нутагтаа төлөвлөн зохион байгуулж, төлөвлөгөө, тайланг сайтдаа тухай бүр байршуулан, иргэд, олон нийтийн оролцоотой хэрэгжүүлнэ.	Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг 2017-2019 онд хэрэгжүүлэх төлөвлөгөөг сумын Засаг даргаар батлуулсан. Төлөвлөгөөнд нийт 27 ажил арга хэмжээ төлөвлөсөн ба 2018 оны жилийн эцсийн байдлаар хэрэгжилт 83,3%-тай байна.	100
1.5	Нийтийн албан тушаалтны хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг хянуулж, шинээр томилогдсон буюу их хэмжээний өөрчлөлтийг 30 хоногт цахимд оруулан “Баталгааны маягт”-аар баталгаажуулан хүлээн авч, ЭБАТ цэсний бүртгэлүүдийг тогтмол хөтөлж хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангана.	2018 онд нийтийн албан тушаалтны хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг шинээр томилогдсон 3 /сумын Засаг даргын орлогч, 1-р багийн Засаг дарга, 2-р багийн Засаг дарга/ албан хаагч гаргаж АТГ-т хянуулсны дараа томилж, томилогдсоноос хойш 30 хоногт багтаан ХОМ-ийг ИТХ-ын ЭБАТ-д өгсөн.	100
1.6	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах, шалгаруулахад оролцох бүрт болон захиргааны акт гаргах,	Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай” хуулийн дагуу ашиг сонирхлын зөрчил үүссэн, үүсч	100

	удирдах, хяналт, шалгалт хийх, хариуцлага хүлээлгэх, гэрээ байгуулах, эдгээрийг хэлэлцэх, бэлтгэх, оролцохын өмнө буюу ашиг сонирхлын зөрчил үүссэн, үүсч болзошгүй тохиолдол бүрт “Ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх, зөрчил үүссэн тухай мэдэгдэл”-ийг тогтмол гаргах, бүртгэлийг цаасаар болон цахимаар хөтөлж хэвшүүлнэ.	болзошгүй нөхцөлд байдал үүссэн талаарх мэдэгдэл, тайлбар 7 ирснийг хүлээн авч бүртгэсэн.	
Хөтөлбөр 2. Гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэхэд чиглэсэн бодлого, хөтөлбөр хэрэгжүүлж, үр дүн, үр нөлөөг дээшлүүлнэ.			
2.1	Нутаг дэвсгэртээ гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх ажлыг аймгийн ГХУСАЗЗ-ийн 2018 оны төлөвлөгөөтэй уялдуулан нэгдсэн төлөвлөгөөтэйгээр зохион байгуулна.	ЗДТГ-т гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын төлөвлөгөөг баталж хэрэгжилтийг сумын ГХУСАЗСЗ-д хүргүүлж ажилласан. Сумын ГХУСАЗСЗ 2018 оны төлөвлөгөөндөө тусгасан ажлуудыг холбогдох байгууллага, албан хаагчидтай хамтран хэрэгжүүлж ажилласан.	100
2.2	Сумын гэмт хэрэг, зөрчлийн шалтгаан нөхцөл болон гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх чиглэлээр багийн Засаг дарга, Цагдаагийн хэсэг, хэсгийн төлөөлөгч нарын зохиож буй ажлын талаарх сонсгол, мэдээллийг сумын Засаг даргын Зөвлөл, ИТХ-ын тэргүүлэгчдийн хурлаар хэлэлцүүлэх, зохих шийдвэр гаргах, дэмжлэг үзүүлэх, хэрэгжүүлэх, үүрэг өгч биелэлт үр дүнг тооцох, эрчимжүүлнэ.	Суманд гарсан гэмт хэрэг болон зөрчлийн талаарх мэдээллийг долоо хоног бүрийн Баасан гариг бүр байгууллагын дарга, эрхлэгч нарын хуралд танилцуулж яриа таниулга сонсгол мэдээллийг хийж ажилладаг. Сумын Засаг даргын зөвлөлийн хурлаар Засаг даргаас ирсэн ажил сайжруулах тухай албан бичгийн дагуу 2018 онд цагдаагийн хэсгийн зүгээс хийж хэрэгжүүлсэн ажлын талаар мэдээлэл сонсгол хийсэн. Мөн сумын ГХУСАЗСЗ-ийн жилийн тайланг сумын ИТХ-ын тэргүүлэгчдийн хуралд танилцуулсан.	100
2.3	Олон нийтийн аюулгүй байдлыг хангах, нийгмийн дэг журам хамгаалах ажилд олон нийтийн эргүүл, хариуцлагатай жижүүр ажиллуулах замаар төрийн албан хаагчид болон иргэд, олон нийтийг зохион байгуулалтаар татан оролцуулж бүх талын дэмжлэг, тусалцаа үзүүлнэ. /Цагдаагийн албаны тухай 24 дүгээр зүйл/	Шинэ жил, Цагаан сар, Мартын-8, Цэргийн баяр, Эх үрсийн баяр, сумын баяр наадам зэрэг олон нийтийг хамарсан арга хэмжээний үеэр олон нийтийн эргүүл, хариуцлагатай жижүүрийг томилж ажиллуулсан.	100
2.4	Архидан согтуурахтай тэмцэх аймгийн бодлого, хөтөлбөр боловсруулахад идэвхтэй оролцох, батлагдсан хөтөлбөрийг орон нутагтаа хэрэгжүүлэх болон архидалтгүй орчин бүрдүүлэхэд чиглэсэн сургалт, сурталчилгаа, нөлөөллийн ажлыг тодорхой судалгаанд үндэслэн төлөвлөж, төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран хэрэгжүүлнэ.	Архидан согтуурахтай тэмцэх чиглэлээр суманд архи согтууруулах ундаа хэтрүүлэн хэрэглэдэг иргэдийн судалгааг шинэчлэн гаргаж сумын АА бүлгийн ахлах Т.Түмэнжаргалтай хамтран архины хор хөнөөлийн талаар 2 удаа сургалт зохион байгуулсан. Согтууруулах ундааны зүйл хэрэглсэн үедээ гэмт хэрэгт холбогдох, оролцсон этгээүүдэд баталгаа бичүүлэн урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулж ажиллаж байна.	100
2.5	Сумын төвийг иж бүрэн гэрэлтүүлэг, камержуулалтыг нэмэгдүүлэх, айл өрх, албан байгууллага, аж ахуй нэгжийн сонор сэрэмж /телекамер, гэрэлтүүлэг, хамгаалалт гэх мэт/ -ийг сайжруулахад иргэд, олон нийтийн татан оролцуулах, тэдний идэвх санаачлагыг өрнүүлж, хулгайн гэмт хэргийг бууруулна.	Сумын төвд 4 гэрэлтүүлэг зоож аж ахуйн нэгж байгууллагыг шаардлага хангасан камертай болох талаар албан мэдэгдэл хүргүүлж ажилласнаар одоогоор суманд 2 байгууллага камертай болсон байна. Сумын цагдаагийн кобоны гаднах гэрэлтүүлгүүдийг шинэчилж ажиллалаа.	70
2.6	Сумдад ажиллаж байгаа цагдаагийн алба хаагчийг орон байр, тээвэр, холбооны хэрэгслээр хангах, түүний гэр бүлийн гишүүнийг ажлын байраар хангахад дэмжлэг үзүүлнэ. /Цагдаагийн албаны тухай хууль 31 дүгээр зүйл/	Цагдаагийн албан хаагчийг ажиллах нөхцөл бололцоогоор хангаж орон байр, тээвэр, шатахуунаар хангаж ажилласан. Цагдаагийн алба хаагчийн гэр бүлийн гишүүнийг ажлын байраар хангаагүй байна.	70

2.7	Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх хуульд заасан үйлчилгээ үзүүлэх үүрэг хүлээсэн ажилтныг сургах, мэргэшүүлэхэд дэмжлэг үзүүлж, уг хуулийг сурталчлах, хяналт тавих, зорилтот бүлгүүдэд чиглэсэн үйл ажиллагааг төрийн болон ТББ-тай хамтран зохион байгуулна.	Гэр бүлийн хүчирхийллийн 2 гомдол мэдээлэл хүлээж авч 1 хүнд баривчилах шийтгэл оногдуулж шүүхээр шийдвэрлүүлсэн. 1 гомдол мэдээллийг сумын хүүхэд хамгааллын хамтарсан багийн хурлаар хэлэлцэж хуулт зүйн зөвлөгөө өгсөн. Гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх чиглэлээр 2 удаа сургалт зохион байгуулж 20 иргэн хамрагдсан.	100
2.8	Малын хулгайн гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд иргэдийн оролцоо, хамтын ажиллагааг нэмэгдүүлэхэд чиглэсэн үйл ажиллагааг хууль сахиулах болон ТББ-тай хамтран зохион байгуулна.	Малын хулгайн гэмт хэрэг 2018 оны хагас жилийн байдлаар 1 бүртгэгдсэн ба хэрэг бүртгэлийн ажиллагаа явуулж байна. Малын хулгайн гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх чиглэлээр иргэдийн оролцоог сайжруулах зорилгоор 4 багт малчдын бүлэг нөхөрлөлийг ажиллуулж байна.	70
2.9	Зөрчлийн тухай хуулийн 17-р зүйлд заасан эрх үүргээ орон нутгийн онцлогтой уялдуулан үр дүнтэй хэрэгжүүлнэ.	Зөрчлийн тухай хуулийн 17-р зүйл буюу замын хөдөлгөөний аюулгүй байдлын журмын эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлж сумын ард иргэдэд боршур сэрэмжлүүлгийг тогтмол тарааж Facebook хаягт тогтмол байршуулж, урьдчилан сэргийлж ажиллаж байна. Одоогоор замын хөдөлгөөний эсрэг гэмт хэрэг 1 бүртгэгдсэн байна.	100

Хөтөлбөр 3. Архив, албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагаанд мэдээллийн технологи нэвтрүүлэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг эрчимжүүлнэ.

3.1	Архивын цахим санд оруулсан мэдээллийг зөөврийн хард диск болон CD дискэнд буулгаж хамгаалалтын болон ашиглалтын цахим хувьтай болгох ажлыг үргэлжүүлж, шаардлагатай дэмжлэг үзүүлж, удирдлага зохион байгуулалтаар хангана.	2004-2016 оны 79 ширхэг байнга хадгалах захирамж, тушаалуудыг сканердаж CD-нд буулгасан. Архивын цахим программын үнэ 330000 төгрөгийг шилжүүлж, программ суулгахад бэлэн болгож архив, албан хэргийн ажилтныг шинэ суурин компьютероор хангасан.	100
3.2	Архивын Ерөнхий газраас 2018 онд зохион байгуулах сургалтанд сум, байгууллагын архив, бичиг хэргийн ажилтнуудыг захиалгын дагуу суралцуулна.	2018 оны 5 сард архив албан хэрэг хөтлөлтийн талаарх сургалтанд хамрагдсан. Сургалтыг архивын ерөнхий газрын сургагч багш Даариймаа, Цэндсүрэн нар явуулсан.	100
3.3	Сайнцагаан, Адаацаг, Хулд, Гурвансайхан, Өлзийт, Эрдэнэдалай Дэлгэрхангай сумдын ЗДТГ болон харьяа байгууллагууд архив, албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагаанд хийх 2018 оны төлөвлөгөөт хяналт, шалгалтад бэлтгэн холбогдох дүрэм, журам, зааврын хэрэгжилтийг хангана.	Хамааралгүй заалт	-
3.4	Архивын нөхөн бүрдүүлэлтийн төлөвлөгөө, графикайн дагуу Өлзийт, Баянжаргалан сумын ЗДТГ-ын архивын баримтаар нөхөн бүрдүүлэлт хийхэд шаардлагатай зохион байгуулалтаар хангаж, дэмжлэг үзүүлнэ.	Хамааралгүй заалт	-

Хөтөлбөр 4. Улсын бүртгэлийн үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлнэ.

4.1	Сумдын бүртгэлийн мэдээллийг онлайн мэдээллийн санд холбох бэлтгэх ажилд бүх талын дэмжлэг үзүүлнэ. /Интернетээр хангах асуудлыг шийдэх/	Сумын ЗДТГ-ын зүгээс улсын бүртгэлийн ажилтныг өндөр хурдны интернэтээр бүрэн хангаж ажиллаж байна.	100
4.2	Сумын төвийн хаягжуулалтыг холбогдох хууль, тогтоомжийн хүрээнд цэгцлэх, шаардагдах зардлыг нарийвчлан тооцож, иргэдийг чирэгдүүлэлгүй шийдвэрлэнэ.	Сумын төвийн хаягжуулалт хийх ажлыг Вектор меп ХХК ОНХС-ийн 4,2 сая төгрөгөөр хийж гүйцэтгэн хүлээлгэн өгсөн.	100

4.3	Бүртгэлийн үйлчилгээний нээлттэй мэдээллийн өдөрлөгийг тусгай хөтөлбөр, удирдамжийн дагуу орон нутагтаа 2-оос доошгүй удаа зохион байгуулна.	ЗДТГ-аас 2018.04.18-ны өдөр нээлттэй хаалганы өдөрлөг зохион байгуулж 23 иргэнд улсын бүртгэлийн үйлчилгээ үзүүлж ажилласан. -Улсын бүртгэлийн хэлтсээс зохион байгуулсан “Бүртгэгч Би Иргэн Таны Төлөө” аяныг сумын хэмжээнд өрнүүлж Баян-Уул хайрханы тахилга” наадмаар иргэдэд мэдээлэл өгч, боршур тарааж, үйлчилгээ үзүүлж 40-50 хүн хамруулж ажиллалаа. Улсын бүртгэлийн 2018 оны 11-р сарын 1-ний өдрөөс хэрэгжих шинэчилсэн хуулиар иргэд, хөдөлмөрчдөд мэдээлэл хийж хуулийн мэдлэгийг дээшлүүлсэн байна.	.100
Хөтөлбөр 5. Хууль зүйн хүрээний мэдээ, тайлагнах ажлыг хугацаанд нь чанартай хэрэгжүүлнэ.			
5.1	Хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлэг гаргах үүрэг бүхий албан тушаалтнуудын нэрсийн жагсаалтыг хүргүүлнэ.	Оны эхэнд хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлэг гаргах үүрэг бүхий албан тушаалтнуудын нэрсийн жагсаалтыг аймгийн ХЭЗХ-т хүргүүлсэн.	100
5.2	Хууль зүйн хүрээнд хийгдсэн ажлын тайлан, мэдээг Хууль зүйн сайдын 2017.07.10-ны А/182 дугаар тушаалаар батлагдсан ажлын үр дүнг үнэлж дүгнэх журмын дагуу тайлагнана.	2018 оны 3-р сарын 1-нд хууль зүйн хүрээнд хийсэн ажлын тайлан мэдээг журмын дагуу гаргаж тайлагнасан.	100
5.3	Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг МУЗГ-ын 2017 оны 89 дүгээр тогтоолоор батлагдсан журмын 5 дугаар хавсралтаар тайлагнана.	Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг 2017-2019 онд хэрэгжүүлэх төлөвлөгөөг сумын Засаг даргаар батлуулсан. Төлөвлөгөөнд нийт 27 ажил арга хэмжээ төлөвлөсөн ба 2018 оны жилийн эцсийн байдлаар хэрэгжилт 83,3%-тай байна.	100
5.4	Нийтийн албан тушаалтнуудын хувийн ашиг сонирхлын болон хөрөнгө орлогын мэдүүлгийг хуулийн хугацаанд цахим бүрдүүлэлтийн програмд бүрэн оруулан баталгаажуулж, АТГ-ын даргын 2012.06.13-ны өдрийн 91 дүгээр тушаалын 1; 3; 4 /ХАСХОМ-1, 3, 4/ дүгээр хавсралтуудыг нэгтгэн хүргүүлнэ..	Нийтийн албан тушаалтнуудын хувийн ашиг сонирхлын болон хөрөнгө орлогын мэдүүлгийг 7 албан хаагчаар гаргуулж хуулийн хугацаанд цахим програмд бүрэн оруулж баталгаажуулж тайлангуудыг хугацаанд нь гаргаж аймгийн ХЭЗХ-т хүргүүлсэн.	100
5.5	Эрх бүхий албан тушаалтан /ЭБАТ/-ны үйл ажиллагааг үнэлсэн тайланг АТГ-ын даргын 2016 оны А/54 тушаалаар батлагдсан шалгуур үзүүлэлтийн дагуу удирдлагаараа үнэлж дүгнүүлэн, тайлагнана.	Сумын ЗДТГ-ын ЭБАТ-ын үйл ажиллагааны тайланг шалгуур үзүүлэлтийн дагуу 2018 оны 3 сард гарган Засаг даргаар үнэлүүлэн явуулсан.	100
5.6	Сумын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны тайланг, тоо баримтад үндэслэн чанартай гаргаж, тайлагнана.	Сумын ГХУСАЗСЗ 2018 онд 22 заалттай төлөвлөгөөг сумын ИТХ-ын даргаар батлуулан хэрэгжилтийг тооцоход 83,5%-тай хэрэгжсэн байна. Хэрэгжилтийг Аймгийн ИТХ-д хүргүүлсэн.	100
5.7	Сумдад Нотариатчийн үүргийг хавсран гүйцэтгэгч нар /сумдын ЗДТГ-ын дарга/-ын нотариатын үйлдэл, үйл ажиллагаанд тавих хяналтыг сайжруулж, үйлчилгээг сайжруулна.	Сумын ЗДТГ-ын дарга нотариатын үүргийг хавсран гүйцэтгэж гэрээ баталгаажуулах 72, итгэмжлэл 37, баримт бичгийн хуулбар 401, гарын үсгийн баталгаа 17-г хийсэн байна. Сумын нотариатын үйлчилгээний талаар санал гомдол гараагүй, чирэгдэлгүй, түргэн шуурхай үйлчилж ажилласан байна.	100
ҮНЭЛГЭЭНИЙ ДУНДАЖ			96,6%

ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ХЭЛТЭС

НИЙГМИЙН БОДЛОГЫН ХҮРЭЭНД ХЭРЭГЖҮҮЛЭХ
ХӨТӨЛБӨР, АРГА ХЭМЖЭЭ

№	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Хэрэгжилт	Хувь
Хөтөлбөр-1: Аймгийн бодлогыг хэрэгжүүлэх талаар			
1.1	“Эрүүл мэндийг дэмжих жил”-ийн ажлын төлөвлөгөөг хэрэгжүүлж, дэвшүүлсэн зорилго, зорилтыг ханган ажиллах	Эрүүл мэндийг дэмжих жил”-ийн ажлын төлөвлөгөөг боловсруулж төлөвлөгөөнд 15 ажил тусгаж сумын Засаг даргаар батлуулан ажилласан. Төлөвлөгөөний хэрэгжилтийг хагас жил болон жилийн эцсийн байдлаар холбогдох газарт нь хүргүүлж ажилласан.	70
1.2	Орон нутгийн хөгжлийн индексийг тооцох нийгмийн хүрээний үзүүлэлтүүдийн суурь судалгааг гаргаж, тодорхой үр дүнд хүргэх ажлыг зохион байгуулах	Аргачлал батлагдсантай холбогдуулан хөгжлийн индекс тооцоход шаардагдах мэдээллийг 2 дугаар сард багтаан “Орон нутгийн хөгжлийн индекс тооцох цахим мэдээллийн систем”-д оруулан баталгаажуулсан.	70
Хөтөлбөр-2: Боловсролын бодлогыг хэрэгжүүлэх талаар			
2.1	“Боловсрол хөгжил”, “Математик”, “Үндэсний бичиг”, “Хүүхдэд ээлтэй дотуур байр” аймгийн хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх	ЕБСургууль аймгийн Засаг даргын 2011 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн А/635 тоот захирамжаар батлагдсан “Математик” хөтөлбөрийн 5 зорилтоос 4 зорилт биелэгдэж 80%, “Хүүхдэд ээлтэй дотуур байр” дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэх 6 зорилт хэрэгжиж ажлын үзүүлэлт 90%, “Үндэсний бичиг” хөтөлбөр 4 зорилт хэрэгжиж ажлын үзүүлэлт 90%, “Боловсрол хөгжил” хөтөлбөрийн 5 зорилт хэрэгжиж 95%-ийн биелэлттэй хэрэгжээд байна.	100
2.2	Бага боловсролын түвшинд “Сургуулийн тэтгэлэгт хөтөлбөр”, STEM сургалтын хэрэглэгдэхүүнд түшиглэн кабинет байгуулан бага ангийн сурагчдын эх хэл, математик, байгалийн ухааны боловсролын чанарыг дээшлүүлж, сурах арга барил эзэмшүүлэх	ЕБС-ийн хувьд анги танхимын хүрэлцээ муутай учраас кабинет гаргах боломжгүй учир STEM сургалтыг 1-5-р ангийн сурагчдын дунд ангид нь багаар ажиллуулах зарчмаар сургалтыг зохион байгуулдаг. Багш бүр ангидаа STEM сургалтыг явуулах төлөвлөгөө боловсруулж төлөвлөгөөний дагуу сургалтыг зохион явуулсан. Мөн сурагчдаар өөрсдөөр нь зохион бүтээлгэж ажилласан. STEM сургалтыг зохион байгуулснаар бага ангийн сурагчдын бүтээлч сэтгэлгээг хөгжүүлж, бие даан ажиллах чадвар нэмэгдсэн. Мөн хүүхэд нэг бүрийн оролцоо шинийг санаачлах санаачлага зохион бүтээх чадвар нэмэгдсэн. Стемийн ширээ, сандал ирсэн. Одоогоор кабинет байгуулахаар төлөвлөөд ажиллаж байна.	100
2.3	Сургуулийн өмнөх боловсролд 5 настай хүүхдийг бүрэн хамруулах	Сумын хэмжээнд 5 настай 21 хүүхэд байна. Үүнээс: Сумын цэцэрлэгт 15 хүүхдийг, өөр аймаг сумын цэцэрлэгт 5 хүүхэд хамрагдаж, өөрийн болон бусад аймаг сумын 1-р ангид нийт 20 хүүхэд элссэн суралцаж, хамран сургалт 96 хувьтай байна. Нэг хүүхэд арын гэрийн шалтгаанаар цэцэрлэгийн бэлтгэл бүлэгт суралцаж байна.	100
2.4	Хэлний бодлогын зөвлөлийг байгуулж, үйл ажиллагааг тогтмолжуулах	Сумын Засаг даргын 2018 оны 7 сарын 19 –ний өдрийн А/61 тоот захирамжаар сумын хэлний бодлогын зөвлөлийг 5 хүний бүрэлдэхүүнтэй байгуулж, жилийн ажлын төлөвлөгөөнд 5 ажил төлөвлөж төлөвлөгөөний дагуу үйл ажиллагааг зохион байгуулан ажилласан. Хэлний бодлогын зөвлөлөөс төрийн байгууллагуудад монгол хэлний зөв бичих дүрмийн сургалт явуулж эхэлсэн ба одоогоор ЭМТ, ЗДТГ, бусад байгууллагуудын нийт 30 хүнд сургалт хийгдээд байна.	70

2.5	Хүүхдийн нийгэмд оролцох оролцоог нэмэгдүүлж, “Нэг сургууль-10 клуб” аяныг зохион байгуулах /Зорилтод сумдад хамааралтай/	Хамааралгүй заалт	
Хөтөлбөр-3: Соёл урлаг, биеийн тамир, спортын бодлогыг хэрэгжүүлэх талаар			
3.1	Өрх бүрийг угийн бичигжүүлэх ажлыг эрчимжүүлэх	Цагаандэлгэр сум нь 388 өрх, 1047 хүн амтайгаас 162 өрх угийн бичгээ хөтөлж байна. Жилийн эцсийн байдлаар сургалтыг 5 удаа 254 иргэнд зохион байгуулж, гарын авлагыг 4 удаа 180 гаруй иргэнд тарааж танилцуулсан байна. Мөн төрийн албан хаагчдын дунд “Өрх бүр угийн бичгээ хөтөлцгөө” уралдааныг зохион байгуулж нийт 22 өрх шинээр угийн бичгээ хөтөлсөн байна. Уут отог боржигинчууд овогтоны “Мөнгөн ургийн баяр” 2018 оны 08-р сарын 18-19-нд Дундговь аймгийн Цагаандэлгэр сумын 4-р багийн нутаг “Цавчирын сүүл толгой” хэмээх зохион байгуулж 400 гаруй хүн оролцсон арга хэмжээ боллоо. Өвөг Балдан, эмэг Чулуун нараас үүсэлтэй 120 гаруй өрхийн 500-аад хүн болж өссөн түүхийг бичсэн ном бүтээж бүх өрхөд гардуулах ажлыг хийсэн байна. Монгол төрийн бодлогыг хэрэгжүүлэхэд 120 гаруй өрх оролцсоны дотор манай сумаас 36 өрх хувь нэмрээ оруулж иргэний үүргээ биелүүлж угийн бичгээ хөтөлсөн байна. 2018 онд шинээр 58 өрх угийн бичгээ хөтөлсөн байна. Сумын хэмжээнд угийн бичиг хөтлөлт 42.8%-тай явж байна. 2017 онтой харьцуувал 15%-иар өссөн байна	100
3.2	ЕБС-ийн Номын санг цахимжуулах	Дундговь аймгийн Төв номын сангаас сургуулийн номын сангуудын компьютерт цахим номын сангийн monbiblio праграммыг суулгасан. Мөн номын санч нарт сургалт зохион байгуулсан. Номын сангийн номнуудыг нэг бүрчилсэн бүртгэлд бүртгэж программдаа 100 ном оруулаад байна. Номын санг цахимжуулах ажил одоогоор 50%-тай явж байна.	40
3.3	“Дуу хуур бидний өв соёл” сумдын соёл урлагийн өдрүүд болон албан байгууллагуудын урлагийн үзлэгийг зохион байгуулж, биет бус соёлын өвийг түгээн дэлгэрүүлэх	2018 оны 04-р сарын 23-нд албан байгууллага, аж ахуй нэгжүүдийн дунд “Авьяаслаг боржигинчууд” ардын урлагийн наадмыг 6 төрлөөр амжилттай зохион байгуулсан. Уралдааны төрөл: 1. Ардын дуу гоцлол 2. Уртын дуу хамтлаг 3. Монгол ардын бүжиг хамтлаг 4. Монгол ардын бүжиг гоцлол 5. Язгуур урлаг 6. Ардын хөгжим гоцлол Тус уралдаанд 4 байгууллагийн 79 албан хаагч оролцсон байна. 2-р шат болох Соёлын биет бус өвийн аймгийн ардын урлагийн их наадамд нийт 9 хүний бүрэлдэхүүнтэй амжилттай оролцсон. Ардын дууны төрөлд Д.Памаасүрэн 3-р байр, улсын уралдаанд оролцох эрхийн бичиг, үзэсгэлэн, гар урлалын төрөлд нийт 13 өвлөн уламжлагчийн 55 үзмэртэй оролцсоноос уламжлалт арьс ширэн урлал төрөлд 4-р багийн малчин П.Сугирсүрэнгийн бүтээл 1-р байр, улсын уралдаанд оролцох эрхийн бичиг, 4-р багийн засаг дарга Д.Мягмардоржийн бүтээл 2-р байр, 4-р багийн өндөр настан Б.Пүрэвдоржийн ширмэл урлал улсын уралдаанд оролцох эрхийн бичиг, 4-р багийн малчин Ч.Даваасүрэн, 1-р багийн иргэн Ц.Энхбатын үзмэр улсын уралдаанд оролцох эрхийн бичгийг тус тус	100

		хүртсэн байна. Нийт үзэсгэлэнгийн төрөлд 14 сум оролцсоноос 2-р байранд орж өндөр амжилт гаргалаа. Мөн угийн бичиг хөтлөлт төрөлд 3-р багийн малчин Ж.Дэлгэрсуурийн хөтөлсөн угийн бичиг 1-р байрыг эзэлсэн. “Нүүдэлчин Монгол-2018” ардын урлагийн наадмын “Намар”-ын өргөөг Цагаандэлгэр, Дэлгэрцогт, Адаацаг, Эрдэнэдалай сумд хамтран тохижуулж ажилттай оролцсон.	
3.4	Морин хуур, уртын дууны сургагч багш нарыг бэлтгэн, сургалт явуулж, морин хуур, уртын дууны хамтлаг, чуулга байгуулан, дуу хуураа өвлүүлэн хөгжүүлэх	Насанд хүрэгчдын дунд уртын дууны дугуйланг 1 удаа хичээллүүлж 79 иргэнд “Уяхан замбуу тивийн наран”, “Энх мэндийн баяр” дууг зааж сургасан байна. Сурагчдын дунд уртын дууны дугуйланг 2 удаа зохион байгуулж 86 сурагчийг хамруулж “Энхмэндийн баяр”, “Хөөрхөн халиун” дууг зааж сургасан байна. Найрал дууны дугуйланг сурагчдын дунд 1 хичээллүүлж 20 сурагчийг хамруулж “Нарны бүжиг” дууг зааж сургалаа. Цэнгээнт бүжгийн дугуйланг сурагчдын дунд 2 удаа зохион байгуулж 23 сурагчийг хамруулж Школны вальс, потсфань, задгай цагаан бүжгийг зааж сургасан. Ардын бүжгийн дугуйланг насанд хүрэгчдийн дунд 2 удаа зохион байгуулж 6 уран сайханчийг хамруулан Жороон жороон, Цагаандэлгэрийн бүжиг, сурагчдын дунд дугуйланг 2 удаа зохион байгуулж нийт 34 сурагчийг хамруулан Салхит шувуу, Бүжигт аялгуу, домог биелгээ, жалам хар, баяд, мянгад, биелгээ зэрэг бүжгүүдийг зааж сургасан байна. Даралтат хөгжмийн дугуйланг сурагчдын дунд 1 удаа зохион байгуулж нийт 4 сурагч хамрагдсан байна.	100
3.5	Түүх соёлын хөдлөх дурсгалын улсын үзлэг, тооллогын ажлыг дэмжиж, хамтран ажиллах	4-р багийн нутаг Шар шороотын бууцны орчимд орших “Хөшөө чулуу” түүх соёлын үл хөдлөх дурсгалын нурсан хашааг босгож, хаяг пайзыг шинэчилж янзалсан. Сумын 1-р багийн нутаг болох Хараатын худаг хэмээх газарт 1ш хиргисүүр, 2ш булш, 2-р багийн нутаг болох Баян-Уул хайрханы орчимд 42ш булшийг илрүүлж бүртгэлд авсан байна. Орон нутгийн тооллогыг багийн Засаг дарга нартай хамтран дурсгалт газарт ойролцоох нутагладаг малчидтай гэрээгээр хариуцуулсан. Тооллогод нийт ТСҮХөдлөх 29 дурсгал хамрагдаж, үүнээс ухагдаж хөндөгдсөн булш, хиргисүүр байхгүй байна. Түүх, соёлын дурсгалын талаар сургалт, мэдээллийг 2 удаа хийж 65 иргэн хамрагдсан. Гарын авлага, танилцуулгыг нийт 4 удаа, 200 гаруй иргэнд, фото үзэсгэлэнг 3 удаа зохион байгуулж 82 иргэн хамрагдсан байна. Сумын хамгаалтанд авах 13 газрыг хамгаалтанд авч ойролцоох нутагладаг малчдад гэрээгээр хариуцууллаа. Түүх соёлын хөдлөх дурсгалын улсын үзлэг, тооллогын ажил хийгдээгүй. 2019 онд манай суманд үзлэг тооллогын ажил хийгдэхээр төлөвлөгөөтэй байна.	100
3.6	Аймгийн ИТХ-ын 2017 оны 04-р сарын 25-ны өдрийн 89 дүгээр тогтоол, Засаг даргын 2016 оны 01 тоот албан даалгаврыг хэрэгжүүлж ажиллах	Түүх соёлын үл хөдлөх 29 дурсгал хамрагдаж, үүнээс ухагдаж хөндөгдсөн булш, хиргисүүр байхгүй байна. Түүх, соёлын дурсгалын талаар сургалт, мэдээллийг 2 удаа хийж 65 иргэн хамрагдсан. Гарын авлага, танилцуулгыг нийт 4 удаа, 200 гаруй иргэнд, фото үзэсгэлэнг 3 удаа зохион байгуулж 82 иргэн хамрагдсан байна. Сумын хамгаалтанд авах 13 газрыг хамгаалтанд	100

		авч ойролцоох нутагладаг малчдад гэрээгээр хариуцууллаа.	
3.7	Соёлын төвийг мэргэжлийн боловсон хүчнээр хангаж, мэргэжил дээшлүүлэх сургалтад хамруулах	Соёлын төв нь 2018 онд 4 орон тоотой үйл ажиллагааг явуулж ажилласан байна. Номын санч Д.Мөнхтуяа СУИС-ийн “Соёлын боловсрол сургууль”-д Номын санч мэдээллийн ажилтан мэргэжлээр 4.5 жил эчнээгээр суралцаж төгссөн, Энэ хугацаанд удирдлагын зүгээс цалинг 100% олгож дэмжлэг үзүүлж ажилласан. Дундговь аймагт эрхлэгч 3 удаа, бүжгийн багш уртын дууны сургагч багш бэлтгэх сургалтад 2 удаа, номын санч 1 удаа тус тус хамрагдсан байна. Мэргэжлийн боловсон хүчний хувь нэмэгдэж, ажилтаны ур чадвар дээшилж ахиц дэвшил гарч үйл ажиллагаа сайжирч байна.	100
3.8	Сумын ЗДТГ-ын дэргэд Биеийн тамир, спортын орон тооны бус зөвлөлийг байгуулан ажиллуулах	Сумын Засаг даргын 2018 оны 7 сарын 19-ны өдрийн А/62 тоот захирамжаар ЗДТГ-ын дэргэд биеийн тамир, спортын орон тооны бус зөвлөлийг 5 хүний бүрэлдэхүүнтэй байгуулан ажиллаж байна. Олон улсын эмэгтэйчүүдийн баярыг тохиолдуулан сумын нийт охид бүсгүйчүүдийн дунд “Гар бөмбөг”-ийн тэмцээнийг зохион байгуулсан. Тэмцээнд нийт 5 баг оролцож 70 гаруй иргэд хамрагдсан. 2018 оны 06 дугаар сард 4 багийн өдөрлөгөөр спортын олон төрөлт уралдааныг амжилттай зохион байгуулж нийт 100 гаруй иргэдийг хамруулсан. Аймгийн “Ахмадын спортын бага наадам”-д 13 ахмад тамирчдыг бэлтгэн оролцуулсан. 10 сарын 04-нд Монгол улсын ерөнхий сайдын ивээл дор зохион байгуулагдсан “Иргэдийн спортын наадам”-ын сумын аварга шалгаруулах уралдааныг ЗДТГазар, Соёлын төвтэй хамтран спортын 5 төрлөөр зохион байгуулсан.	100
3.9	Хүн амын бие бялдрын хөгжил чийрэгжилтийн түвшин тогтоох сорилыг орон нутагт үр дүнтэй зохион байгуулах	Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2010 оны “Нийтийн биеийн тамир спортыг хөгжүүлэх тухай 53 дугаар зарлигийн хэрэгжилтийг хангах зорилгоор хүн амын бие бялдарын хөгжил, чийрэгжилтийн түвшин тогтоох сорилыг орон нутагт 4 сарын 30,31 ны өдрүүдэд зохион байгуулж сорилд 50 иргэн, 80 хүүхэд хамрагдсан.	100
3.10	Иргэдийн дунд идэвхтэй дасгал хөдөлгөөнийг өрнүүлж, нийтийн биеийн тамирыг хөгжүүлэх	ЗДТГ-ын ажилтан албан хаагчид 11 цагт ажлын байрны дасгал хөдөлгөөн хийж байна. ЭМТ-өөс “Идэвхтэй хөдөлгөөн-эрүүл амьдрал аян”-ыг 2 сараас НЭМС Г.Энхжаргал эхлүүлж цэцэрлэгийн 9 багш, ажилчдад ажлын байрны дасгал хөдөлгөөний заасан байна. Олон улсын эмэгтэйчүүдийн баярыг тохиолдуулан сумын нийт охид бүсгүйчүүдийн дунд “Гар бөмбөг”-ийн тэмцээнийг зохион байгуулсан. Тэмцээнд нийт 5 баг оролцож 70 гаруй иргэд хамрагдсан. 2018 оны 06 дугаар сард 4 багийн өдөрлөгөөр спортын олон төрөлт уралдааныг амжилттай зохион байгуулж нийт 100 гаруй иргэдийг хамруулсан. Аймгийн “Ахмадын спортын бага наадам”-ыг 2018 оны 6 сарын 6-ны өдөр хөгжилтэй буухиа, олс таталт, теннис, гэсэн 3 төрлөөр зохион байгуулж 70 гаруй ахмад тамирчид хамрагдсан. “Ахмадын спортын бага наадам”-аас шалгарсан 13 ахмад тамирчдыг бэлтгэн аймгийн шигшээ тэмцээнд оролцуулсан. 10 сарын 04-нд Монгол улсын ерөнхий сайдын ивээл дор зохион байгуулан даж буй “Иргэдийн	100

		спортын наадам"-ын сумын аварга шалгаруулах уралдааныг ЗДТГазар, Соёлын төвтэй хамтран спортын 5 төрлөөр зохион байгуулсан. Мөн төрийн албан хаагчдын анхдугаар зөвлөгөөнөөр "Гар бөмбөг" болон "Шатар"-ын тэмцээнийг зохион байгуулж нийт 80 гаруй иргэд хамрагдсан байна. Үүний үр дүнд иргэдийн чөлөөт цагаа зөв боловсон өнгөрүүлж, хөдөлгөөний дутагдлаас сэргийлсэн байна. Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2010 оны"Нийтийн биеийн тамир спортыг хөгжүүлэх тухай 53 дугаар зарлигийн хэрэгжилтийг хангах зорилгоор хүн амын бие бялдарын хөгжил, чийрэгжилтийн түвшин тогтоох сорилыг орон нутагт 4 сарын 30,31 ны өдрүүдэд зохион байгуулж сорилд 50 иргэн, 80 хүүхэд хамрагдсан. "Нутаг усаараа бахархаж" явган аялалыг 2018 оны 11 дугаар сарын 07-ны өдөр төрийн албан хаагчдын дунд амжилттай зохион байгуулсан. Тус уралдаанд нийт 6 байгууллагын 42 албан хаагч оролцож, олс таталтын төрөлд 1-р байранд хүүхдийн цэцэрлэг, морин байлдаан төрөлд 1-р байранд жижиг байгууллагууд, сумо эрэгтэй төрөлд хүүхдийн цэцэрлэгийн жижүүр Баасансүрэн, эмэгтэй төрөлд ЭМТөвийн сувилагч Бямбажаргал, уулын оргил булаалдах төрөлд жижиг дунд байгууллагууд тус тус тэргүүн байрыг эзэллээ. Явган аялалын маршрутыг сумын төвд байрлах "Ембүү овооноос – сумын тахилгат Хараат" уул хүртэл үргэлжилсэн юм.	
3.11	БТСГ-ын зохион байгуулж буй графикт тэмцээн, уралдаан, сургалтад идэвхтэй хамрагдах	2018 оны 6 сарын 15-16 ны өдрүүдэд 4 багийн өдөрлөгөөр ахмадын спортын бага наадмын анхан шатны тэмцээнийг 5 төрлөөр сумандаа зохион байгуулсан. "Ахмадын спортын бага наадам"-д шалгарсан 13 ахмад тамирчдыг бэлтгэн оролцуулсан. 10 сарын 04-нд Монгол улсын ерөнхий сайдын ивээл дор зохион байгуулагдсан "Иргэдийн спортын наадам"-ын сумын аварга шалгаруулах уралдааныг ЗДТГазар, Соёлын төвтэй хамтран спортын 5 төрлөөр зохион байгуулж шалгарсан тамирчдыг Дундговь аймагт зохион байгуулагдсан "Иргэдийн спортын наадам"-ын шигшээ тэмцээнд оролцуулсан.	100
3.12	Үндэсний спортын VI их наадмын зохион байгуулалттай оролцох	Хугацаа болоогүй байна.	-
Хөтөлбөр-4: Гэр бүл, хүүхэд, залуучуудын бодлогыг хэрэгжүүлэх талаар			
4.1	Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийг сурталчлан, иргэдэд мэдээлэл хүргэж ажиллах	2018 ны 3 сарын 9,10 нд болсон "Таван эрдэнэ-2" малчдын зөвлөгөөний үеэр "Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх" тухай хуулиар сургалт хийж, багийн дарга нар хөдөөгийн малчин өрхөөр явж цаг үеийн ажил байдалтай танилцаж мэдээлэл хүргэхээр явахтай холбогдуулж тус хуулиар гарын авлага хийж хөдөөгийн малчин 120 гаруй өрхөд хүргэсэн. Мөн хуулийн мэдээллийн цагаар "Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль"иар цагдаа Ч.Эрдэнэбулган сургалт зохион байгуулж сургалтанд 25 төрийн албан хаагч иргэд хамрагдлаа.	100
4.2	Гэр бүлийн хүчирхийллийг бууруулах, таслан зогсооход	Гэр бүлийн хүчирхийллийг бууруулах, таслан зогсооход чиглэгдсэн нөлөөллийн үйл ажиллагааг зохион байгуулахаар ГХУСАСЗ-ийн гишүүдтэй 2018 онд хамтран ажиллах төлөвлөгөө гаргаж	

	чиглэгдсэн нөлөөллийн үйл ажиллагааг зохион байгуулах	төлөвлөгөөний дагуу урьдчилан сэргийлэх, таслан зогсооход чиглэсэн үйл ажиллагаануудыг зохион байгуулсан. Мөн хүчирхийлэлтэй айл өрхийн судалгаа гарган бүртгэлжүүлж гэр бүлийн хүчирхийлэл дахин үйлдэхгүй байх талаар ИТХ-ын ажлын албатай хамтран соён гэгээрүүлэх сургалт сурталчилгааны ажлыг зохион байгуулж гэр бүлийн хүчирхийллийн судалгааны бүртгэлд нийт 4 иргэнийг бүртгээд байна.	70
4.3	Гэр бүлийн хүчирхийллийн шалтгаан нөхцөлийг тогтоох зорилготой фокус бүлгийн ярилцлагыг зохион байгуулах	Гэр бүлийн хүчирхийлэл үйлдсэн 1 хүнд баривчилах арга хэмжээ авч гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх чиглэлээр сургалтанд хамруулж зөвлөгөө өгч ажилласан	70
4.4	Хамтарсан багийг нэгдсэн удирдлагаар хангаж, тогтвортой ажиллах нөхцөлийг бүрдүүлэх	Сумын хүүхэд хамгааллын хамтарсан багийг Сумын ИТХ-ын 2017 оны 11 сарын 27 ны өдрийн 39 дугаар тогтоолоор 10 хүний бүрэлдэхүүнтэйгээр байгуулсан. Дундговь аймагт 2018 оны 4 сарын 24,25-нд Хүүхэд хамгааллын хамтарсан багийн гишүүдийг чадваржуулах 16 цагийн сургалтанд багаараа хамрагдаж гэрчилгээ авсан. Хүүхэд хамгааллын хамтарсан багийн 2018 оны ажлын төлөвлөгөөг сумын Засаг даргаар 3 сарын 22-нд батлуулж хэрэгжүүлж ажилласан байлаа. ЗДТГ-ын “Нээлттэй хаалга”-ны өдрөөр хүүхэд хамгааллын тухай хуулиар гарын авлага бэлтгэж 25 хүнд тараасан. Хэсгийн төлөөлөгч Т.Адъяабат дунд сургуулийн хүүхдүүдэд “Гэмт хэрэгээс урьдчилан сэргийлэх” чиглэлээр сургалт хийсэн. Хүүхэд хамгааллын хамтарсан баг нь 2018 онд хүүхэд рүү чиглэсэн 8 ажил төлөвлөж төлөвлөгөөний дагуу “Инээж буй хүүхэд” нэртэй хүүхдийн анхдугаар чуулганыг 2018 оны 5 сарын 16-нд амжилттай зохион байгуулсан. ГХУСАЗСЗөвлөлтэй хамтран ерөнхий боловсролын ахлах ангийн сурагчдад “Хүүхдийн эрхийг хамгаалах тухай” хууль, “Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай” хууль-иар сургалт хийж “Замын хөдөлгөөний дүрэм”-р видео бичлэг үзүүлж сумын хүүхэд хамгааллын хамтарсан багийн гишүүдийг танилцуулж, яаралтай түргэн тусламжид хандах утасны дугаарыг тэмдэглүүлэн хүүхдүүдтэй нээлттэй ярилцаж санал бодлыг сонсож ажиллалаа. 2018 оны 6 сарын 22-нд Жаргалан багийн нутаг дэвсгэрт болсон “Цагаан-Уул”-ын тахилга наадам, Аймгийн тахилгат “Баян-Уул” хайрханы тахилга наадам, сумын баяр наадамд наадмын морины комисстой хамтран ажиллаж уралдаанд оролцож байгаа хүүхдийн аюулгүй байдал, стандартын хувцас хэрэгсэлтэй, 7-оос дээш насны хүүхдийг уралдаанд оролцуулах, даатгалд хамруулсан байх, эцэг, эх асран хамгаалагчийн зөвшөөрөл зэргийг шалгаж хяналт тавьж ажиллалаа. ХХХБаг 4 удаа хуралдаж 6 асуудал хэлэлцэж шийдвэрлэсэн. Сумын хүүхэд хамгааллын бодлого боловсруулж ИТХ-д хүргүүлсэн.	100
4.5	Залуучуудын салбар зөвлөлийн үйл ажиллагааг дэмжин, Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хууль сурталчилж ажиллах	Сумын залуучуудын бүлгэмийг сумын Засаг даргын 2017 оны 11 сарын 22 ны өдрийн А/56 тоот захирамжаар 8 хүний бүрэлдэхүүнтэйгээр байгуулсан. 15-34 насны залуучуудын судалгааг 4 багаас нэгтгэж судалгаанд 15-34 насны 300 залуучууд хамрагдсан. “Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хууль”-р хууль мэдээллийн цагаар сургалт зохион байгуулж нийт 25 төрийн албан хаагч иргэд хамрагдлаа. Аймгийн ЗДТГ, ГБХЗХГ-	100

		аас анх удаа зохион байгуулж “Бидний аав-бидний ирээдүй” аавуудын анхдугаар чуулганд 22-39 насны 9 аав оролцсон. Мөн 2018 оны 12 сарын 1 нд Дундговь аймагт болсон залуучуудын бүлгэмийн гишүүдийг чадавхижуулах сургалтанд бүлгэмийн зөвлөлийн 4 гишүүн хамрагдаж ирсэн. Хүн амын тооллогоор малчин өрхөөр явж байгаа ажлын хэсгийн гишүүдэд залуучуудын хөгжлийн төвийн мэдээлэл болон, залуучуудын хөгжлийг дэмжих тухай хуулийн гол үндсэн заалтуудаар 60 ширхэг мэдээлэл гарын авлага бэлтгэж 15-34 насны залуучуудад тараалаа.	
4.6	Хүүхэд, өсвөр үе, залуучуудад гэр бүлийн боловсрол олгох, амьдрах ухааны чадвар эзэмшүүлэх сургалт зохион байгуулах	Насан туршийн боловсролын нэгж нь хүүхэд, өсвөр үе, залуучуудад амьдрах ухааны боловсрол, гэр бүлийн боловсрол, иргэний боловсрол, ёс суртахуун-төлөвшилийн боловсрол, Эрүүл мэнд, ёс суртахууны боловсрол, гоо зүй-мэдрэмжийн боловсрол, шинжлэх ухааны чиглэлээр боловсрол олгох үйл ажиллагаа зохион байгуулж ажиллалаа. Залуучуудад зориулсан багаар ажиллах чадвар, харилцаа, бүтээлч чадварыг хөгжүүлэх, амьдрах ухааны сургалтыг цэргийн насны залуучуудад 10 сарын 7-нд ЗДТГ-тай хамтран зохион байгууллаа. Дүйцсэн хөтөлбөрт хамрагдаж байгаа сурагчдад суралцагч бүрт модуль сургалтын материалыг гарын авлага болгон бэлтгэж хүргүүлж 10 сурагчдаас 10 сурагч нь өөрийн түвшингээсээ ахисан. Суурь боловсрол эзэмших 6 сурагчдаас 6 сурагч суурь боловсрол эзэмшсэн. Залуучуудад дүйцсэн сургалтын модулиар зайны сургалт 2 удаа явуулсан. Төрийн албан хаагч залуучуудад англи хэлний 1 сарын сургалтыг 10 сард зохион байгуулж 21 хүн, багш нарт 7 хоногийн сургалтанд 14 багш, англи хэлний хүүхдийн авъяас хөгжүүлэх сургалтанд 14 сурагч хамрагдсан байна. Гэр бүлийн боловсрол олгох чиглэлээр 2 төрлийн сургалтыг эцэг эхчүүдэд “Нас сэтгэхүйн онцлогт тохируулан хүүхэдтэйгээ харьцах” Хүүхэд гэр бүлийн баялаг сургалт, амьдрах ухааны чиглэлээр эсгий урлалын сургалт, санхүүгийн боловсрол олгох хөтөлбөр ногоо тариалах, хүнсний ногоо даршлах, оёдлын сургалт зэрэг сургалтуудыг зохион байгуулж нийт 33 удаагийн сургалтанд давхардсан тоогоор 955 хүн хамрагдсан байна.	100
4.7	Хүүхдийн хөгжил хамгааллын үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх	Хүүхдийн хөгжил хамгааллын үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх жилийн ажлын төлөвлөгөөг 9 чиглэлээр гарган хэрэгжүүлж ажиллалаа. Цэцэрлэгийн “Хүүхэд хамгааллын бодлого”-ын баримт бичгийг дахин шинэчилэн боловсруулж, багш ажилчид, эцэг эхийн хурлаар баталгаажууллаа. Бүлэг бүр ангийн дүрэм гаргаж хүүхдүүдээ хэвшүүлэн ажиллаж байна. Хүүхэд хамгааллын хамтарсан багаас Хүүхэд хамгааллын тухай, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай, Хүүхдийн эрхийг хамгаалах тухай хуулиудын сургалтанд цэцэрлэгийн бүлгийн багш нар, эцэг эхийн төлөөлөл нийт 25 иргэн хамрагдаж зөвлөгөө авлаа. ГХУСАЗСЗөвлөлтэй хамтран ерөнхий боловсролын ахлах ангийн сурагчдад “Хүүхдийн эрхийг хамгаалах тухай” хууль, “Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай” хууль-иар сургалт хийж “Замын хөдөлгөөний дүрэм”-р видео бичлэг үзүүлж сумын хүүхэд хамгааллын хамтарсан багийн гишүүдийг танилцуулж,	100

		яаралтай түргэн тусламжид хандах утасны дугаарыг тэмдэглүүлэн хүүхдүүдтэй нээлттэй ярилцаж санал бодлыг сонсож ажиллалаа. Сургууль, цэцэрлэгийн хүүхдүүдэд Говьугтаал сумын сум дундын эмнэлгийн шүдний эмч Д.Цогтбаатар эмч 5 сарын 4-6-ны хооронд чих хамар хоолой, шүдний урьдчилан сэргийлэх үзлэг зохион байгуулж 76 хүүхэд хамрагдсанаас 10 хүүхэд эмчилгээнд орсон байна. 11 сарын 30 –с эхлэн сургуулийн 78 хүүхэд, СӨБ-ийн 57 хүүхдийг үзлэгт хамруулсан байна. СӨБ-ийн хүүхдүүдийг 7 хоногт 1 удаа урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулж сард нэг удаа өндөр жинг нь үзэж багш нартай хамтран ажилласан. Мөн сумын хүүхэд хамгааллын бодлогыг боловсруулж сумын Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн сумын ИТХ-д хүргүүлсэн.	
Хөтөлбөр-5: Эрүүл мэндийн бодлогыг хэрэгжүүлэх талаар			
5.1	Эмч мэргэжилтнүүдийн ёс зүй, харилцаа хандлагын зөрчлөөс урьдчилан сэргийлж, хамтран ажиллах	Эмч эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн алдаа зөрчил илрээгүй. Нийт 18 эмч эмнэлгийн мэргэжилтэнд ёс зүйн дотоодын сургалт зохион байгуулсан. Эрүүл мэндийн газрын хүний нөөцийн мэргэжилтэнд ёс зүйн сургалтанд хамрагдах мэргэжилтнүүдийн нэрсийг явуулсан байна.	70
5.2	Эрдэнэдалай, Луус, Цагаандэлгэр, Говь-Угтаал сумдын ЭМТөвд эм найруулагчийг богино хугацаагаар бэлтгэх	Мэргэжлийн эм найруулагчгүй, багийн бага эмч С.Оюунбатыг 2017 оноос одоог хүртэл хавсран ажиллуулж байна. Эмийн санч мэргэжлээр суралцах хүн байгаа боловч санхүүгийн шалтгаанаас болж суралцаж чадахгүй байна.	40
5.3	Гадаад хамтын ажиллагааг эрчимжүүлж, өргөжүүлэн нарийн мэргэжлийн эмч, сувилагч, эмнэлгийн тусгай мэргэжилтнүүдийг туршлага судлуулж, мэргэшүүлэн сургах	Эрүүл мэндийн чанар хүртээмжийг сайжруулах зорилгоор чанарын багийн төлөвлөгөө гаргаж, графикийн дагуу хяналт тавин ажилласан. Мөн чанарын сургалтанд 4 сард Дундговь аймагт ЭМТ-ийн дарга Б.Мөнхчимэг, эмчлэгч эмч А.Өлзийжаргал нар хамрагдсан. Эмч мэргэжилтнүүдийн мэдлэг мэргэжлийг дээшлүүлэхэд анхаарч НЭМС-ийг 5 сард нийгмийн эрүүл мэндийн сургалтанд хамруулсан. Сувилагч Б.Мөнхтамир Улаанбаатар хотод Халдвар судлалын төвд 3 сарын вакцинактор сувилагчаар мэргэжил дээшлүүлсэн. Мөн дүн бүртгэгч С.Энхтөр Улаанбаатар хотод эрүүл мэндийн хөгжлийн төвд 3 сарын статистикийн сургалтанд суралцаж төгссөн. Их эмчийн тоог нэмэгдүүлж багийг их эмчтэй болгох ажлын хүрээнд 2-р багийг их эмчтэй болгосон. Сувилагчийн нөөц мэргэжилтэн бэлтгэх ажлыг эрүүл мэндийн газарт саналаа дэвшүүлсэн	100
5.4	Эрдэнэдалай, Сайхан-Овоо, Адаацаг, Луус сумдын эрүүл мэндийн төвүүд зөөврийн ЭХО-той болох	Хамааралгүй заалт	-
5.5	Сүрьеэ, БЗДХ-ын өвчлөл өндөртэй Сайнцагаан, Говь-Угтаал, Гурвансайхан, Адаацаг, Эрдэнэдалай сумдад урьдчилан сэргийлэх, тандалт судалгаа, илрүүлэг үзлэг, шинжилгээ, оношилгоог эрчимжүүлэх	Хамааралгүй заалт	-
5.6	Зонхилон тохиолдох халдварт бус артерийн гипертензи, чихрийн шижин 2 хэв шинж, хөх, умайн хүзүүний өмөнгийн эрт илрүүлэг үзлэгт зорилтот бүлгийн иргэдийг	Артерийн даралт ихдэлт, Чихрийн шижин 2 хэв шинж эрт илрүүлэгт 4 багийн 257 иргэн хамруулахаас 210 иргэн хамраглаж 80%-тай байна. Умайн хүзүү болон хөхний хавдраас урьдчилан сэргийлэх үзлэгт зорилтот насны нийт 326 эмэгтэй хамрагдахаас 2018 онд 247	100

	хамруулж, эмчлэн эрүүлжүүлэх ажлыг хийж үр дүнг тооцох	эмэгтэйчүүдийг хамруулсан. Үүнээс хөхний хавдрын эрт илрүүлэг үзлэгт 256 эмэгтэй хамрагдахаас 202 хамрагдаж 79%, умайн хүзүүний эрт илрүүлэг үзлэгт 70 хамрагдахаас 45 хамрагдаж 64%-тай хамрагдсан. Умайн хүзүүний эрт илрүүлэг үзлэгээс 6 эмэгтэй хавдрын урьдал илэрч шаардлагатай эмчилгээг зөвлөж 6 сарын дараа давтан үзлэгт хамруулахаар шийдвэрлэсэн.	
5.7	Элэгний В,С вирусын халдвар, элэгний хавдрын илрүүлэлтийг эрчимжүүлж ажиллах	Элэгний В, С вирусийн шинжилгээнд хамрагдах судалгааг гаргаж аймгийн ЭМГ-т хүргүүлсэн. Үүнээс 104 иргэнийг хамруулах шинжилгээний багц ирснээс 104 иргэнийг бүрэн хамруулсан. Шинжилгээнд орон нутагт түр оршин суугаа 2 иргэн, 40-өөс дээш насны 6 иргэнийг нэмэлтээр хамруулж нийт 112 иргэнийг хамруулсан. 10 иргэн В вирус, 1 иргэнд С вирус илэрч дараагийн шатлалын эмнэлэгт вирус тоолуулах шинжилгээ өгөхөөр илгээсэн. 2018.06.06-нд аймгийн НЭ-ээс дотор, эмэгтэйчүүд, ЭХО, сүрьеэгийн эмч нар ирж хавдрын эрт илрүүлэг үзлэг хийж 56 иргэн хамрагдсан.	100
5.8	Албан байгууллага, аж ахуйн нэгжүүд ажилчид болон ахмадуудаа урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулж, эрүүлжүүлэх.	2018 оны 4 сарын 18-д ЗДТГ-тай хамтран нээлттэй хаалганы өдөрлөг зохион байгуулж 82 иргэд хамрагдаж, даралт ихсэлттэй 4 иргэнийг эмнэлэгт хэвтүүлж эмчлүүлсэн. 6 сарын 6-нд аймгийн нэгдсэн эмнэлгийн нарийн мэргэжлийн дотор, хүүхэд, эхо, эмэгтэйчүүдийн эмч нар ирж үнэ төлбөргүй үзлэг хийж 67 иргэд хамрагдлаа. “Элэг бүтэн Монгол” үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэн ажиллаж байна. Бие бялдарын чийрэгжүүлэлтийн сорилд 51 төрийн албан хаагч хамрагдсан. 2018 онд 61 ахмадыг эмнэлэгт хэвтэн эмчлүүлэх болон үзлэг шинжилгээнд хамруулах гэрээр үйлчилгээ үзүүлэх зэрэг эмнэлгийн тусламж үйлчилгээнд хамруулсан байна.	100
Хөтөлбөр-6: Жендэрийн эрх тэгш байдлыг хангах чиглэлээр			
6.1	Жендерийн эрх тэгш байдлыг хангах үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх сумын салбар хорооны төлөвлөгөөг батлуулж хэрэгжилтийг хангах	Жендерийн эрх тэгш байдлыг хангах үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх сумын салбар хорооны төлөвлөгөөг батлуулан ажиллаж байна. 2018 оны 5 сарын 9, 10 нд Улаанбаатар хотод болсон “Жендерийн тэгш байдал- Орон нутгийн хөгжилд сэдэвт сургалтанд нийгмийн бодлогын мэргэжилтэн хамрагдсан. 2018 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилт 80% тай хэрэгжсэн байна.	70
6.2	Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн хэрэгжилтийг эрчимжүүлж, төрийн захиргааны болон нутгийн захиргааны байгууллагад ажиллагсдын хүйсийн тэнцвэрт байдлын тайланг гарган хугацаанд нь тайлагнах	Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн хэрэгжилтийг эрчимжүүлж, төрийн байгууллагад ажиллагсдын хүйсийн тэнцвэрт байдлын тайланг гарган хугацаанд нь тайлагнах. Судалгаанд 82 төрийн албан хаагч хамрагдсан.	100
6.3	Жендэрийн эрх тэгш байдлыг хангах талаар төрийн албан хаагчид болон иргэдэд сургалт зохион байгуулж сурталчилах	2018 оны 10 сарын 24–нд хуулийн мэдээллийн цагаар “Жендерийн эрх тэгш байдлыг хангах тухай” хуулиар сургалт зохион байгуулж сургалтанд нийт 30 төрийн албан хаагч, иргэд хамрагдлаа.	100

Хөтөлбөр-7: Эрүүл мэнд, нийгмийн даатгалын чиглэлээр			
7.1	Нийгмийн даатгалын сайн дурын	2018 оны байдлаар шинээр сайн дурын даатгалд 15 иргэн гэрээ байгуулж нийтдээ 125 иргэн даатгалд хамрагдаж байна. НД-ын хуулийн талаар сургалт сурталчилгааг хийж	100

	даатгалын хамралтыг нэмэгдүүлэх	ажилласан. 4 багийн иргэдийн нийтийн хурал болон өдөрлөгөөр мэдээлэл хийсэн. 2018 оны 9 сарын 21-нд Нийгмийн даатгалын “Нээлттэй хаалганы өдрийг зохион байгуулсан. 2018 оны 11 сарын 29-30-ны хооронд 4-р багийн Засаг дарга Мягмардоржтой хамтран нийт 20 өрхөөр орж иргэдийг даатгалдаа хамрагдахыг уриалан мэдээлэл хийсэн.	
7.2	Эрүүл мэндийн даатгалын хамралтыг нэмэгдүүлэх	2018 онд нийт эрүүл мэндийн шимтгэлийг 187 иргэд төлсөн. 2018 онд төрөөс хариуцах эрүүл мэндийн даатгалд 45 иргэн нэмж хамрагдсан. Үүнд төрсөн эх 6, 0-19 нас хүртэлх хүүхэд 16, хөдөлмөрийн чадвараа түр алдсан иргэн 2, өндөр насны тэтгэвэр авагч өндөр настан 14, халамжаас тэтгэвэр авагч иргэн 2, халамжийн хүнсний талонд хамрагддаг 1 иргэн байна. Энэ онд нийт 232 иргэн эрүүл мэндийн даатгалд хамрагдаад байна.	100
7.3	Нийгмийн даатгалын шимтгэлийн орлогын төлөвлөгөөг жигд ханган биелүүлэх	Нийгмийн даатгалын сангийн төвлөрсөн харилцахад орсон орлогыг 5 санд хувиарлалт хийж ЭМД-ын сан, ҮО-ын сангийн орлогыг төвлөрүүлж, харилцахын баримтыг сар бүрийн 5-ны дотор аймагт хүргүүлж ажиллаж байна. 2018 оны байдлаар төвлөрсөн харилцахад 148410540.04 төгрөг орлогодож дараах 5 санруу хувиарлав. Үүнд: ☐ Тэтгэвэр 103234374 ☐ Тэтгэмж 11620545 ☐ Эрүүл мэнд 25808592 ☐ Ажилгүйдэл 2582343 ☐ Үйлдвэрлэлийн осол 5164686 төгрөгийг тус тус хувиарлав.	100
7.4	Нийгмийн даатгалын хууль тогтоомжийг иргэд даатгуулагч нарт сурталчилах	4 сарын 2-нд сумын иргэний танхимд нийгмийн даатгалын багц хуулиудаар сургалт зохион байгуулж нийт 38 иргэн хамрагдсан. 4 сарын 23 -нд ХААН банк, ЭМТөв хүн олноор үйлчлүүлдэг газрууд дээр очиж 28 хүнд нийгмийн даатгалын ач холбогдлын талаар мэдээлэл өгч сурталчилгаа хийж танилцуулах материал тараасан. 9 сард жил бүр зохиогддог нийт 4 багийн өдөрлөгөөр малчид ард иргэдтэй уулзаж сургалт суртчилгаа тараах материал тараасан. 2018 оны 9 сарын 21-нд Нийгмийн даатгалын өдөрлөгийг зохион байгуулсан. 2018 оны 11 сарын 29-30-ны хооронд 4-р багийн Засаг дарга Мягмардоржтой хамт 20 өрх айлгаар орж малчидад НД талаар зөвлөгөө өгч мөн тэтгэвэрт тогтоолгох болж буй иргэдийн хөдөлмөрийн дэвтэр, нийгмийн даатгалын дэвтэр зэргийг үзэж шимтгэл төлсөн жилийг тоолж, тараах материал өгч ажилласан.	100

Хөтөлбөр-8: Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний чиглэлээр

Хэрэгжүүлэх арга хэмжээ	Хэрэгжилт	Хувь
Нэг. “Хөдөлмөрийн харилцаа, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн арга хэмжээг хэрэгжүүлэх” гэсэн байгууллагын стратегийн зорилтыг хангахад чиглэсэн хөтөлбөр, арга хэмжээ:		
1.1 Хөдөлмөрийн тухай хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах	Хөдөлмөрийн харилцаанд оролцож байгаа бүх иргэд ААНБ-ууд хөдөлмөрийн тухай хуулийг мөрдөж, ажилтан албан хаагчид хуульд заасан эрхээ эдэлж хөнгөлөлт чөлөөлөлт, тэтгэмж урамшууллаа авч үүргээ ухамсарлан ажиллаж байна.	100
1.2 Нутаг дэвсгэрийн аж ахуйн нэгж, байгууллагуудад шинэчлэн тогтоосон хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс багагүй цалин хөлс олгохыг мөрдүүлж хэвшүүлэх	Нутаг дэвсгэрийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж, байгууллагууд 2017 оны 1 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн мөрдөж байгаа шинэчлэн тогтоосон хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг баримтлан иргэдэд цалин хөлс олгон ажиллаж байна.	100
1.3 Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах	ХАБЭА-н салбар зөвлөлийг сумын Засаг даргын захирамжаар шинэчлэн байгуулсан. Зөвлөлийн гишүүдийг гарын авлагаар ханган 3 удаа хуралдаж ажлын төлөвлөгөө гаргасан. Төлөвлөгөөний дагуу байгууллагын дарга нар	70

	ажилчдад хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн талаар сургалт мэдээлэл хийж байна. Байгууллага бүрт үйлдвэрлэлийн осол, хурц хордлогыг судлан бүртгэх орон тооны бус байнгын комисс ажиллуулах аргачилсан зөвлөмжийг хүргэсэний дагуу ЗДТГ, Эрүүл мэндийн төв, Хүүхдийн цэцэрлэг, Соёлын төв комисс байгуулан ажиллаж байна. ХАБЭА -н чиглэлээр мэргэжлийн хяналтын улсын байцаагчийн хамт 5 байгууллага, 1 ХКК-аар орж хяналт хийсэн. Мөн албан байгууллагаар орж налуу замын хяналтын хэмжилт хийж байгууллагын дарга нарт зөвлөгөө өгсөн.	
1.4 Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн талаар 3 багийн иргэдийн нийтийн хурал болон мэдээллийн цагаар сумын төвийн иргэдэд сургалт хийсэн. Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төсөлд хамрагдсан 1 малчны малыг багийн засаг даргын хамт явж хүлээлцсэн. Жижиг зээлийн төсөлд хамрагдахаар 5 иргэн материал ирүүлснээс 2 иргэн санхүүжилтээ аван үйл ажиллагаагаа явуулж байна.	10 0
1.5 Өрхийн амьжиргааны түвшин тогтоох судалгааны ажлыг орон нутагт зохион байгуулах	Өрхийн амьжиргааны түвшин тодорхойлох дахин судалгааны ажлыг удирдамж чиглэлийн дагуу тухай бүрд нь зохион байгуулсан. Энэ онд 46 өрхийг судалгаанд хамруулсан.	10 0
1.6 Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нийгэмших, хөгжих, хөдөлмөрлөх зэрэг бүхий л харилцаанд оролцох эрхийг ханган орчин нөхцлийг бүрдүүлэх	Албан байгууллагын налуу замд хяналтын хэмжилт хийж хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд ээлтэй аймаг болох зорилт тавин ажиллаж байгаа талаар байгууллагын дарга нарт мэдээлж налуу замыг стандартын дагуу хийх талаар зөвлөгөө өгсөн. Дундговь аймагт зохиогдсон хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн чуулганд сумын төлөөлөл 4 иргэнийг оролцуулсан.	70
1.7 Зорилтод өрхийн хөгжил хамгааллыг сайжруулах үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг хангаж ажиллах	Мэргэжилтэн ажлаасаа гарч дараагийн хүн томилогдох хүртэл хугацаа их алдаж ажил удаашрана гэсэн үүднээс зорилтод өрхийн хөгжил хамгааллыг сайжруулах үндэсний хөтөлбөрийг энэ онд манай суманд хэрэгжүүлээгүй.	-
ҮНЭЛГЭЭНИЙ ДУНДАЖ		93,2%

НИЙГМИЙН БОДЛОГЫН ХЭЛТЭС

ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ ҮНЭЛГЭЭ ДОТООД АУДИТЫН ХҮРЭЭНД
ХЭРЭГЖҮҮЛЭХ ХӨТӨЛБӨР АРГА ХЭМЖЭЭ

Д/д	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Хүрэх үр дүн, шалгуур үзүүлэлт	Хувь
1	Сумын Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийн тайланг аймгийн Засаг даргын 2017 оны 12 дугаар сарын 11-ний өдрийн А/452 тоот захирамжаар батлагдсан журмын 3 дугаар хавсралтын дагуу гаргаж хяналт шинжилгээ үнэлгээ хийн үнэлгээний дүнг 2018 оны 11 сарын 15-ны дотор ИТХ-аар хэлэлцүүлэн тайлан мэдээг ИТХ-ын тогтоол болон хурлын тэмдэглэлийн хамт Төрийн захиргааны удирдлагын хэлтэст 11 сарын 25-ны дотор ирүүлэх	Аймгийн Засаг даргын 2017 оны 12 дугаар сарын 11-ний өдрийн А/452 тоот захирамжаар батлагдсан журмын 3 дугаар хавсралтын дагуу сумын Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2018 оны хэрэгжилтийг жилийн эцсийн байдлаар гарган тайланг ХШҮДАХ-т хүргүүлсэн.	100
2	Сумын эдийн засаг нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн хэрэгжилтийн тайланг аймгийн Засаг даргын 2017 оны 12 дугаар сарын 11-ний өдрийн А/452 тоот захирамжаар батлагдсан журмын 4 дүгээр хавсралтын дагуу гаргаж хяналт шинжилгээ үнэлгээ хийн үнэлгээний дүнг ИТХ-аар хэлэлцүүлэн 2018 оны 11 сарын 25 - ны дотор тайлан мэдээг ИТХ-ын тогтоол болон хурлын тэмдэглэлийн хамт Төрийн захиргааны удирдлагын хэлтэст ирүүлэх	Аймгийн Засаг даргын 2017 оны 12 дугаар сарын 11-ний өдрийн А/452 тоот захирамжаар батлагдсан журмын 4 дүгээр хавсралтын дагуу сумын 2018 оны эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн хэрэгжилтийн тайланг гарган хүргүүлсэн.	100
3	Сумын Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх дэд хөтөлбөрийн тайланг аймгийн Засаг даргын 2017 оны 12 дугаар сарын 11-ний өдрийн А/452 тоот захирамжаар батлагдсан журмын 5 дугаар хавсралтын дагуу гаргаж хяналт шинжилгээ үнэлгээ хийн үнэлгээний дүнг ИТХ-аар хэлэлцүүлэн 2018 оны 09 сарын 15 - ны дотор тайлан мэдээг ИТХ-ын тогтоол болон хурлын тэмдэглэлийн хамт Төрийн захиргааны удирдлагын хэлтэст ирүүлэх	Сумын Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэхээр баталсан дэд хөтөлбөр байхгүй. Цаашид дэд хөтөлбөрүүдийг баталж хэрэгжүүлж ажиллахаар төлөвлөсөн. Үндэсний хөтөлбөрүүд болон аймгийн дэд хөтөлбөрүүдийн хэрэгжилтийг хагас бүтэн жилээр тооцож биелэлтийг хүргүүлж ажилласан.	40
4	Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоол, аймгийн Засаг даргын 2017 оны 12 дугаар сарын 11-ний өдрийн А/452 тоот захирамжаар батлагдсан журмуудаар байгууллагын дарга эрхлэгч нар болон төрийн албан хаагчдад сургалт зохион байгуулж, тайлан мэдээ гаргахад мөрдөн ажиллах	Байгууллагын дарга эрхлэгч, нийгмийн бодлогын мэргэжилтэнд аймгийн Засаг даргын 2017 оны 12 дугаар сарын 11-ний өдрийн А/452 тоот захирамжаар батлагдсан журмыг танилцуулж мэдээлэл хийсэн.	100
ҮНЭЛГЭЭНИЙ ДУНДАЖ			85%
НИЙТ ҮНЭЛГЭЭНИЙ ДУНДАЖ ХУВЬ			90,5%

ТАЙЛАН ГАРГАСАН: ЗДТГ-ЫН ДАРГА

З.СОЛОНГО

ХЯНАСАН: ЗАСАГ ДАРГА

Д.БУДЖАВ